



УНЦЛАГА

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

- БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль
- БНМАУ-ын Гаалийн хууль
- БНМАУ-ын Намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

БНМАУ-ын Бага Хурлын Тамгын газар

1991 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ)

БНМАУ-ын Бага Хурлын Тамгын Газар

№ 2

1991 оны хоёрдугаар сар

(2)

ГАРЧИГ

I. БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ БНМАУ-ЫН ХУУЛЬ

Хуудасны дугаар

1. Хууль батламжлах тухай № 8	105
2. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хууль	106
3. Хууль батламжлах тухай № 9	107
4. БНМАУ-ын Газарын хууль	108
5. Хууль хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хууль	119
6. БНМАУ-ын Эрүүгийн байдлын шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай БНМАУ-ын хууль	120
7. Хууль батламжлах тухай № 10	121
8. БНМАУ-ын Газрын тосны тухай хууль	122
9. Хууль батламжлах тухай № 11	127
10. БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль	128
1. Хууль, хуулийн заалтууд хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хууль	154

II. БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

2. Цэргийн зарим тусгай шүүхийг татан бууцах, шилжүүлэн байршуулах тухай № 6	150
3. Цэргийн тусгай шүүхийн зарим шүүгчийг сонгох, чөлөөлөх тухай № 7	156
4. Зарим хуулийн төслийн тухай № 8	158

15. БНМАУ-ын Гаалийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 9	159
16. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 12	162
17. БНМАУ-ын шүүгчийн тангараг баталт тухай № 13	165
18. Монголий хуваарь (масштаб) өөрчлөгдсөнтэй холбогдууаан хууль, зарлиг, тогтоолын зарим заалтыг хэрэглэх журмын тухай № 14	166
19. Дүрэм батлах тухай № 15	167

III. БНМАУ-ЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН ЗАРАЛГ

20. Дипломат ажлалтын тангараг батлах тухай № 1	174
21. Дүрэм батлах тухай № 6	175
22. БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх зөвөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай № 7	180
23. БНМАУ-ын Спортын гавьяат дасгалжуулагч цол олгох тухай № 30	183
24. БНМАУ-ын Гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 31	183
25. Зарим тамирчдыг шагнах тухай № 32	184
26. Мигжэд Жаарайсыг шүтээнийг бүтээн залах тухай № 33	185

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 2 дугаар

Дугаар 8

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хуулийг зөвшөөрөн батламжиласугай.

**Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч**

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХУУЛЬ

1991 оны 1 дүгээр
сарын 26-ны өдөр

Улсынбаяр
хот

ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хуулийн хоёр дугаар зүйлийн хоёр дахь хэсгийг «Намын байгууллаагч гэгцхүү нутаг дэвсгэрийн шинжээр байгуулж болно. Энэ заалт үйлдвэрчний эвлэлээс бусад улс төрийн үйл ажиллагаа явуулах улс төр-олон нийтийн байгууллаагад нэгэн адил хамаарна» гэж өөрчлөн найруулсугай.

2. Мөн хуулийн 3 дугаар зүйлд «Иргэний хувийн байдлыг тодорхойлсон аливаа албаны бичиг баримтад хуульд зааснаас бусад тохиолдолд тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр аль намын гишүүн болох талаар тодорхойлохыг хориглоно» гэсэн гурав дахь хэсгийг нэмсүгэй.

3. Мөн хуульд дор дурдсан агуулгатай 4^д дүгээр зүйлийг нэмсүгэй:

«4^д дүгээр зүйл. Намын гишүүний болон төрийн албан хаагчийн үүргийг зааглах

Төрийн албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ аль нэг намын эрх ашгийн үүднээс бус гэгцхүү улсын эрх ашгийн үүднээс хандаж эрх зүйн хэм хэмжээнд захирагдан ажиллана.»

3. Энэ хуулийн 1 дүгээр заалтыг БНМАУ-ын шүүх, прокурор, цагдаа, дэвсгэг хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон засан дэмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудад БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилсан өдрөөс, бусад байгууллаагад 1991 оны 7 дугаар сарын 1-нээс, 2, 3 дугаар заалтыг БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилсан өдрөөс тус тус дагаж мөрдсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
варийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИГЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 2 дугаар

Дугаар 9

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Гагалийн хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай хуулийг тус тус зөвшөөрөн батламжласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ГААЛИЙН ХУУЛЬ

НЭГДҮГТЭЭР БҮЛЭГ

Нийтлэл үндэслэл

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Гаалийн хуулийн зорилт

БНМАУ-ын Гаалийн хуулийн зорилт нь БНМАУ-ын тусгаар тогтнол, эрх ашиг, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, гадаад улстай худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тус дөхөй үзүүлэх зорилгоор БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр гаалийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

2 дугаар зүйл. Гаалийн хуулиар зохицуулах харилцаа

Энэ хууль нь гаалийн татвар, хураамжийн талаар нэгдсэн бодлого явуулах, гаалийн тоо бүртгэлийг хөтлөх, гаалийн хууль тогтоомж зөрчих явдалтай тэмцэх, БНМАУ-ын улсын хилээр оруулах, гаргах, дамжин өнгөрүүлэх (цаашид «нэвтрүүлэх» гэх) ачаа тээш, эд юмс, оюуны бүтээл, мал, амьтан, ургамал, валют, валютын болон бусад үнэт зүйлс, олон улсын шуудан илгээлт (цаашид «бараа» гэх), агаарын хөлөг, галт тэрэг, автомашины, усан онгоц, ердийн хөсөг гэх мэт (цаашид «тээврийн хэрэгсэл» гэх) бүх төрлийн тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулана.

3 дугаар зүйл. БНМАУ-ын гаалийн хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. БНМАУ-ын гаалийн хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. БНМАУ-ын олон улсын гэрвэнд энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон байвал олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэр, хил

1. БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэр нь БНМАУ-ын нутаг дэвсгэр байна.

2. БНМАУ-ын улсын хил, гаалийн тусгай бүс болон гаалийн агуулахыг БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарласан тодорхой тэмдэг бүхий шугамыг гаалийн хил гэнэ.

ХОЕРДУГААР БҮЛЭГ

Гаалийн хяналт шалгалт

5 дугаар зүйл. БНМАУ-ын улсын хилээр бараа, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх

1. БНМАУ-ын улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг хилэйн боомт, хилэйн гарц (цаашид «хилэйн гарц» гэх) бүхий газраар гаалийн хяналт шаалгалт хийж нэвтрүүлэнэ.

2. Гаалийн байгууллаагагүй хилэйн гарцаар бараа, тээврийн хэрэгслийг БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх зайлшгүй шаардлага гарвал гаалийн удирдах төв байгууллаагаас зөвшөөрөл авна.

6 дугаар зүйл. Зарим барааг БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах

Зарим барааг шаардлагатай тохиолдолд БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэхийг БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр хориглож, хязгаарлаж болно.

7 дугаар зүйл. Гаалийн мөдүүлэг

БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн байгууллаагаас тогтоосон маягтын дагуу гаалийн мөдүүлэг үйлдэнэ.

8 дугаар зүйл. Гаалийн хяналт шаалгалт

1. БНМАУ-ын улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүвэлт хийх, шаалгах, тодорхой үндэслэл байгаа бол гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгсэл болон хүний биед үзлэг хийх замаар гаалийн хяналт шаалгалтыг хэрэгжүүлэнэ.

2. Шаардлагатай үед гаалийн хяналт шаалгалтыг гаалийн байгууллаагагүй газарт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр гүйцэтгүүлж болно.

3. Гаалийн хяналт шаалгалт хийхдээ зорнуулатын хэрэгсэл ашиглаж болох бөгөөд гаалийн хяналт шаалгалтыг дахин хийж болно.

4. Бараа, тээврийн хэрэгсэл эзэмшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гаалийн хяналт шаалгалт хийлгэх бэлтгэлийг хангаж, хяналт шаалгалтын үед байлцах үүрэгтэй.

5. Бараа, тээврийн хэрэгсэл эзэмшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гаалийн хяналт шалгалт хийгдэж байгаа барааг ачих, буулгах, задлах, сав, баглаа боодлыг нь өөрчлөх, тээврийн хэрэгслийг хөдөлгөөхийг гагцхүү гаалийн байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

6. БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийх журмыг эрх бүхий холбогдох байгууллаагатай хамтран гаалийн удирдах төв байгууллаага батална.

7. Шаардлагатай тохиолдолд зарим нэрийн онцлог барааг гаалийн байгууллаага, эрх бүхий холбогдох мэргэжлийн байгууллаагатай хамтран тогтоосон журмын дагуу гаалийн хяналт шалгалт хийнэ.

8. Эдийн засгийн гадаад үйл ажиллагаа явуулах эрх олгогдсон байгууллагын экспорт, импортын бараанд гаалийн хяналт шалгалт хийж БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлнэ.

9. БНМАУ-ын Засгийн газраас эрх олгосон байгууллаагаас экспорт, импортын зөвшөөрөл (лиценз) авах шаардлагатай барааг тухайн зөвшөөрлийг үндэслэн БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлнэ.

9 дүгээр зүйл. Гаалийн хяналт шалгалт хийх хугацаа

Гаалийн байгууллаага гаалийн хяналт шалгалтыг бараанд 3 хоногийн дотор, тээврийн хэрэгсэлд тухайн тээврийн хэрэгслийн хуваарьт хугацаанд багтаан дуусгах үүрэгтэй бөгөөд гаалийн хяналт шалгалтын зайлшгүй тохиолдолд дээр дурдсан хугацааг сунгаж болно.

10 дүгээр зүйл. Гаалийн хяналт шалгалт хийсэн барааг хадгалах

Гаалийн хяналт шалгалт хийсэн барааг гаалийн байгууллагын агуулахад, эсвэл гаалийн байгууллагын зөвшөөрснөөр тээврийн байгууллаага, бараа эзэмшигчийн мэдэлд хадгалуулж болно.

11 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэлд хийх гаалийн хяналт шалгалт

1. Тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалтыг тээврийн холбогдох байгууллаагад гаалийн байгууллаагатай тохиролцож тогтоосон талбайд хийнэ. Тээврийн хэрэгслийг тохиролцол тогтоосон талбайгаас өөр газар зогсоох шаардлагатай тохиолдолд тээврийн байгууллаага буюу тээврийн хэрэгслийг эзэмшигч нь энэ тухай гаалийн зохих байгууллаагад нэг даруй мэдэгдэж, гаалийн хяналт шалгалт хийлгэнэ.

2. Тээврийн байгууллага буюу тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгаалт хийхэд шаардагдах бүх төрлийн мэдээллээр гаалийн байгууллагыг хангаж, төлөөлөгчөө байлцуулан гаалийн улсын байцаагчид мөргөжлийн бүх талын туслаалцаа үзүүлэх үүрэгтэй.

3. Гаалийн хяналт шалгалтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд хийж болох бөгөөд энэ тохиолдолд тээврийн байгууллага, гаалийн улсын байцаагчийг зохих нөхцөлөөр хангах үүрэгтэй.

4. Нэг бичиг баримттай барааг салгаж тээвэрлэхийг хориглоно.

12 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх

1. Бараа, тээврийн хэрэгслийг нэг жилийн дотор буцааж оруулах буюу гаргах нөхцөлөөр БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэхийг түр хугацаагаар нэвтрүүлэх гэнэ.

2. Хамтын үйлдвэр болон гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх түр хугацааг гаалийн байгууллагаас өөрөөр тогтоож болно.

13 дугаар зүйл. Гаалийн хяналт шалгалтыг гадаад орны нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх

Хярицан тохиролцсон нөхцөлд гаалийн хяналт шалгалтыг гадаад орны хилийн гаалийн хяналтын бүсэд хэрэгжүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гаалийн татвар, хураамж

14 дүгээр зүйл. Гаалийн татвар

1. БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрсөн бараанд гаалийн татварын тарифын дагуу татвар ногдуулна. Гаалийн татварыг барааны гэрээний үнийг франко-Монгол улсын хилийн үнэд шинэжүүлэн тухайн өдрийн валютын ханшийг үндэслэн гаалийн татварыг тарифын дагуу тооцно.

2. Гаалийн татварын тарифыг БНМАУ-ын Бага Хурал батална.

3. Шаардлагатай гэж үзвэл улсын үйлдвэрийн газар, байгууллагын импортын бараанд гаалийн татвараас гадна худалдааны татвар ногдуулж болно. Худалдааны татварын хувь, хэм-

жээ, түүнийг ногдуулах, татан авах журмыг БНМАУ-ын Засгийн газар батална.

4. Бараа эзэмшигч нь барааны үнийг тодорхойлсон бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.

15 дугаар зүйл. Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа

БНМАУ-ын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дор дурдсан барааг гаалийн татвараас чөлөөлнө:

1) БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байгуулах гадаадын хөрөнгө оруулаалттай үйлдвэрийн газар, байгууллагын дүрмийн санд оруулах, тэдгээрээс үйлдвэрлэлээ явуулахад шаардагдах;

2) БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байгаа гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат агуулахад оруулах;

3) гадаад орны захиалагчийн материалаар БНМАУ-д бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон БНМАУ-ын захиалагчийн материадаар гадаад оронд бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор нийлүүлэх;

3) түр хугацаагаар БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх;

5) буруу тэвэрлэсний улмаас буцааж нэвтрүүлэх;

6) хүмүүнлэг тусламжийн болон тахир дутуу иргэдэд зориулсан;

7) БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх.

16 дугаар зүйл. Гаалийн хураамж

1. Гаалийн бүрдүүлээт хийсэн, үйлчилгээ үзүүлсэн болон гаалийн агуулахад бараа хадгалсны хөлсийг гаалийн хураамж гэнэ.

2. Гаалийн хураамжийг гаалийн удирдах төв байгууллага нэгдсэн журмаар тогтооно.

17 дугаар зүйл. Гаалийн татвар, хураамжийг төлөх

1. Гаалийн татвар, хураамжийг гаалийн байгууллага хурааж авна.

2. Гаалийн татвар, хураамжийг гэрээ байгуулагч төлнө.

3. Гаалийн байгууллага нь гаалийн татвар, хураамжийг бүрэн барагдуулах баталгаа болгож тэдгээрийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний барааг барьцаанд авч болно.

4. Гаалийн татвар, хураамжийг БНМАУ-д хүлээн авахыг зөвшөөрсөн гадаадын валютаар төлж болно.

5. Зорчигчдоос БНМАУ-ын улсын хилээр гаалийн татваргүй нэвтрүүлэх хувийн хэрэглээний эд юмсын тоо, гаалийн татварын тариф, хураамжийн хэмжээг эрх бүхий холбогдох

байгууллагатай зөвшөөрөлцсөний үндсэн дээр гаалийн удирдах төв байгууллага тогтоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат агуулах

18 дугаар зүйл. Гаалийн тусгай бүс тогтоох, гаалийн баталгаат агуулах байгуулах

1. БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн тусгай бүс тогтоож, гаалийн баталгаат агуулах байгуулж болно.

2. БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр гаалийн тусгай бүс тогтоох, гаалийн баталгаат агуулах байгуулахыг БНМАУ-ын Засгийн газар шийдвэрлэнэ.

19 дүгээр зүйл. Гаалийн тусгай бүс

1. БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарлагдсан, гадаад гэж тооцогдох, монголын болон гадаадын, олон улсын нэгжээс гаалийн тусгай нөхцөлөөр аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох нутаг дэвсгэрийг гаалийн тусгай бүс гэнэ.

2. БНМАУ-ын Засгийн газраас гаалийн тусгай бүс тогтоохдоо түүний хилийг зааж, монголын гаалийн нутаг дэвсгэрээс ялгах арга, тусгай бүсийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлно.

3. Гаалийн тусгай бүсвэс гадаадтай болон тус улсын бусад бүс нутагтай бараа эргэлт явуулахад тавих гаалийн хяналтын журмыг БНМАУ-ын Засгийн газар батална.

20 дугаар зүйл. Гаалийн баталгаат агуулах

БНМАУ-ын гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарлагдсан, гадаад гэж тооцогдох, монголын нутаг дээр байрладаг монголын болон гадаадын, олон улсын нэгжээс бараа хадгалэх, боловсруулах, жижиглэн савлах, засвар хийх зэрэг бусад үйлчилгээ явуулах нутаг дэвсгэрийг гаалийн баталгаат агуулах гэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

БНМАУ-ын гаалийн байгууллага

21 дүгээр зүйл. Гаалийн байгууллагын тогтолцоо

1. Гаалийн байгууллага нь БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх гаалийн удирдах төв байгууллага, түүний харьяа гаа-

лийн газар, хилийн болон гүний гаалийн байгууллагаас бүрдэнэ.

2. Гаалийн удирдах төв байгууллага, түүний харьяа гаалийн газар, хилийн байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг БНМАУ-ын Засгийн газар шийдвэрлэнэ.

3. Гаалийн газар, хилийн гаалийн байгууллагын хариуцсан гаалийн бүсэд гаалийн төлөөлөгч, эдийн засгийн гадаад үйл ажиллагаанд оролцдог үйлдвэрийн газар, байгууллагын дэргэд гүний гаалийн байгууллага, тэдгээрт гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллуулахыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Гаалийн байгууллагыг удирдах

БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр гаалийн үйл ажиллагааг гаалийн удирдах төв байгууллага удирдана.

23 дугаар зүйл. Гаалийн байгууллагын үйл ажиллагааны зарчим

Гаалийн байгууллага нь үйл ажиллагаандаа хууль ёсыг чанд сахих, бусдын нөлөөнд үл автагдах, доод шатны гаалийн байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд захирагдах зарчмыг удирдлага болгоно.

24 дүгээр зүйл. БНМАУ-ын гаалийн ажилтан.

1. БНМАУ-ын гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн хяналт шалгалт хийх эрх эдэлж, үүрэг хүлээсэн ажилтныг гаалийн улсын байцаагч гэнэ.

2. Гаалийн улсын байцаагч нь БНМАУ-ын засаг захиргааны төлөөлөгч байх бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу үүрэг хүлээж, эрхээ хамгаалуулна.

3. Гаалийн улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ биеэ хамгаалах зэвсэг хэрэглэж болно. Зэвсэг эзэмших, хэрэглэх журмыг Улсын Ерөнхий прокурорын зөвшөөрснөөр гаалийн удирдах төв байгууллага тогтооно.

4. Гаалийн улсын байцаагч БНМАУ-ын Засгийн газраас тогтоосон мэргэжлийн цол, гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон дүрэмт хувцас хэрэглэнэ.

5. Гаалийн улсын байцаагч нь «Гаалийн ажилтан би гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг гагцхүү БНМАУ-ын хуульд захирагдан хэний ч нөлөөнд үл автан хэрэгжүүлж байгууллага, иргэн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг удирдлага болгон явуулахаа батлан тэнгэрэглэж байна» гэсэн тэнгэрэг өргөх бөгөөд тэнгэрэглэснээс нэцгэл гаалийн улсын байцаагч байх эр

хавь аддаж зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6. Гаалийн улсын байцаагч сахлагын тусгай дүрмээр хариуцлага хүлээнэ. Энэхүү дүрмийг БНМАУ-ын Засгийн газар батална.

7. Гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ зүйлийн 5-д заасны дагуу тангараг өргөж, хариуцлага хүлээнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хариуцлага

25 дугаар зүйл. Хариуцлага хүлээлгэх үндэслэл

1. Гаалийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлын хэмжээг харгалзан хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Дор дурдсан үйлдэл (эс үйлдэл)-ийг гаалийн хууль тогтоомж зөрчсөнд тооцож, хариуцлага хүлээлгэх үндэслэл болгоно:

1) БНМАУ-ын улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан;

2) БНМАУ-ын улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлсэн;

3) энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үндэслэлээр хориглосон буюу хязгаарласан барааг нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхийг завдсан;

4) БНМАУ-ын улсын хилээр оюуны бүтээлийг хууль бусаар нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхийг завдсан;

5) БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн гаалийн мэдүүлэг болон гаалийн хяналт шалгалт снийхэд шаардагдах баримт бичгийг гаалийн байгууллагад гаргаж өгөөгүй, зохих журмын дагуу мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн;

6) гаалийн хяналт шалгалт хийгдэж байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй ачсан, буудгасан, шилжүүлэн ачсан, эвэмшигчид нь олгосон, сав, баглаа боодол, хаягийг санаатайгаар гэмтээсэн буюу өөрчилсөн;

7) БНМАУ-ын улсын хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн барааг тогтоосон хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр буцаан нэвтрүүлээгүй;

8) БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг тохиролцож тогтоосон талбайгаас өөр газар зогсоож, энэ гухайгаа гаалийн холбогдох байгууллагад мэдэгдээгүй;

9) гаалийн хяналт шалгаат хийгдэж байгаа тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөж явуулсан;

10) бараа, тээврийн хэрэгсэл, агуулах, чингэлэгт гаалийн байгууллагаас тавьсан аац, ломбо, тэмдгийг санаатайгаар гэмтээсэн буюу арилгасан;

11) гаалийн хяналт шалгаалтыг санаатайгаар саатуулсан;

12) гаалийн ажиглалтын хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн буюу биелүүлээгүй;

13) гаалийн татвар, хураамжийг цаг хугацаанд нь төлөөгүй, төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн;

14) БНМАУ-ын гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн бусад үйлдэл.

26 дугаар зүйл. Гаалийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Гаалийн хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

1) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан зөрчил гаргасан этгээдийг тухайн зөрчилд хамаарагдах барааг хураах буюу хураахгүйгээр үнийн дүнгийн 5 хүртэл хувиар торгоно;

2) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан зөрчил гаргасан этгээдийг тухайн зөрчилд хамаарагдах барааны үнийн дүнгийн 10 хүртэл хувиар торгож, барааг хураан авч, тээврийн хэрэгслийг саатуулна;

3) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан зөрчил гаргасан этгээдийг бараа, оюуны бүтээлийг нь хураан авч 2000 хүртэл төгрөгөөр торгоно;

4) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5—12-т дурдсан зөрчил гаргасан иргэдийг 1000 хүртэл төгрөгөөр, уг зөрчлийг албан тушаалаа ашиглан үйлдсэн албан тушаалтныг 2000 хүртэл төгрөгөөр тус тус торгоно;

5) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 13-т дурдсан зөрчил гаргасан байгууллага, иргэн зохих барааны үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх торгуулийг (алданги) хоног тутамд төлнө;

6) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 14-т заасан гаалийн хууль тогтоомжийн бусад зөрчилд зохих хууль тогтоомжоор хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлагын арга хэмжээг гаалийн улсын байцаагч ногдуулна.

3. Торгуулийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зохих хугацаанд нь төлөөгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар гаргуулна.

4. Торгуулийг үндэслэлгүй ногдуулсан буюу барааг үндэслэлгүй хураасан гэж үзвэл захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргаж болно.

27 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийг хураах

Барааг хууль бусаар БНМАУ-ын улсын хил нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл эзэмшигч нь түүнийг нуувч болгон ашигласан тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг бараан хамт хураах бөгөөд бололцоогүй бол тэдгээрийн үнийг зохих этгээдээс гаргуулан авна.

28 дугаар зүйл. Хураасан бараа, хураасан буюу саатуулсан тээврийн хэрэгслийг буцаан олгох

1. Энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хураасан бараа, мөн зүйл болон 27 дугаар зүйлд заасны дагуу хураасан буюу саатуулсан тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага 2 сар (чанараа түргэн алдах барааг 7 хоног)-ын дотор эзэмшигчид буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь буцааж өгнө. Хэрэв энэ хугацаанд буцаан аваагүй, эсвэл эзэмшигч нь илрээгүй бол БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу түүнийг улсын орлого болгоно.

2. Хууль бусаар БНМАУ-ын улсын хилээр нэвтрүүлсэнтэй холбогдуулж хураасан бараа, тээврийн хэрэгслийг уг хэрэгт холбогдолгүй гэж 1 жилийн дотор нотлогдвол түүнийг буцаан олгох бөгөөд хэрэв буцаан олгох боломжгүй бол зохих хууль тогтоомжийн дагуу суутгал ногдуулж гаалийн байгууллага үнийг нь төлнө.

29 дугаар зүйл. Гаалийн хяналт шалгалт хийхтэй холбогдсон материалын хариуцлага

Гаалийн хяналт шалгалт хийгдэж байгаа барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн тээвэрлэхтэй холбогдсон зардал, хохирлыг гаалийн байгууллага хариуцахгүй.

30 дугаар зүйл. Гаалийн байгууллагаас хэрэг бүртгэх

1. БНМАУ-ын улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхээр завдсан этгээдийн үйлдэл нь контрабандын гэмт хэргийн шинжтэй байна гэж үзвэл хяналт шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч акт үйлдэж БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу контрабандын гэмт хэргийг бүртгэх эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

2. Контрабандын хэргийг бүртгэх эрхийг гаалийн удирдах төв байгууллагын харьяа гаалийн газрын дарга, хилийн болон гүний гаалийн байгууллагын эрхлэгч нар эдэлнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан актыг холбогдох өтгээд зөвшөөрөөгүй бол түүнийг үйлдсэн өдрөөс хойш 2 долоо хоногийн дотор, хэрэв хилийн чанадад яваа бол 2 сарын дотор гаалийн холбогдох дээд шатны байгууллагад гомдол гаргаж болно.

БНМАУ-ын Бага Хурал
орлогч дарга

К. ЗАРДЫХАН

БНМАУ-ын Бага Хурал
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 1 дүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ХУУЛЬ**

1991 оны 1 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын Гаалийн хуулийг дагаж мөрдөх өдрөөс эхлэн 1973 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн «БНМАУ-ын Гаалийн хууль»-ийг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
варийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ХУУЛЬ**

1991 оны 1 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

**БНМАУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр
зүйлэд:

«8) гаалийн газрын дарга, хилийн болон гүний гаалийн бай-
гууллаагын эрхлэгч-контрабандын гэмт хэргийн талаар» гэсэн
дэд хэсгийг нэмсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
сарын бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 2 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Газрын
тосны тухай хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

БНМАУ-ын газрын тосны тухай хуулийн зорилт нь БНМАУ-ын болон гадаад улсын байгууллага, иргэдээс тус улсын газрын хэвлийд оршиж буй газрын тосыг хайх, хамгаалах, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

1. «Газрын тос» гэсэн ойлголтод газрын хэвлийд байгаа шингэн тос, хий болон хатуу байдалтай хамтад нь буюу дангаар нь олборлож болох нүүрс-ус төрөгчийн төрөл бүрийн нэгдлийг хамааруулна.

2. «Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа» гэсэн ойлголтод газрын тос хайх, хамгаалах, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах ажиллагааг хамааруулна.

3. «Газрын тосны хэрэг эрхлэх байгууллага» гэж БНМАУ-ын Засгийн газраас газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих эрх олгосон байгууллагыг хэлнэ.

4. «Гэрээлэгч» гэж тус улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай гэрээ байгуулсан БНМАУ-ын болон гадаад улсын байгууллага, иргэнийг хэлнэ.

3 дугаар зүйл. Газрын тосыг өмчлөх

БНМАУ-ын газрын хэвлийд байгаа газрын тос нь зөвхөн төрийн өмч байна.

4 дүгээр зүйл. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг төрөөс удирдах

1. БНМАУ-ын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагааг зөвхөн БНМАУ-ын Засгийн газар болон газрын тосны хэрэг эрхлэх байгууллагын зөвшөөрөлтэйгээр явуулна.

2. БНМАУ-ын Засгийн газар нь улс үндэсний аюулгүй байдлыг хангах, газрын тосны орд-байгалийн агууламжид гэмтэл, хүн ам, байгаль орчинд хохирол учруудахаас урьдчилан сэргийлэх, түүх, соёлын үнэт зүйлийг хамгаалах зорилгоор нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт газрын тос олборлохыг хориглох буюу хязгаарлах шийдвэр гаргаж болно.

3. Газрын тосны хайгуулын хөтөлбөрийг боловсруулж, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг зөвхөн газрын тосны хэрэг эрхлэх байгууллага өдөлнө.

4. Энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг БНМАУ-ын Засгийн газар батлан гаргана.

5 дугаар зүйл. Гадаадын гэрээлэгчийн эрх зүйн байдал

БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын гэрээлэгч нь БНМАУ-ын хуулийн этгээд, иргэдийн нэг адил БНМАУ-ын эрх зүйн хамгаалалтад байж, БНМАУ-ын хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

ХОЕРДУГААР БҮЛЭГ

Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа

6 дугаар зүйл. Газрын тосны тухай гэрээнд тавих үндсэн шаардлага

Газрын тосны тухай гэрээнд дор дурдсан үндсэн шаардлага тавигдана:

1) газрын хэвлэлд байгаа ордын нөөцийн 20-иос доошгүй хувийг олборлож чадахуйц техник технологийг хэрэглэх;

2) БНМАУ-д газрын тос боловсруулах үйлдвэр бий болгон хөгжүүлэхийг эрхэмлэх;

3) мэргэжилтэй ажилтан бэлтгэх, гадаадын иргэдийг хөлс-лөн ажиллуулах асуудлыг шийдвэрлэх;

3) газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд эдийн засгийн өндөр үр ашигтай, хүрээлэн байгаа орчны зохист тэнцвэрийг алдагдуулахааргүй техник, технологи хэрэглэх;

5) газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тухай бүх мэдээ, баримт, тайланг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагад бүрэн эхээр нь шилжүүлэх;

6) хүн амын аюулгүй байдлыг хангах, ажиллагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх

арга хэмжээ авах, эд хөрөнгө, байгалийн нөөц баялаг, газар, түүний хэвлэл болон хүрвэлэн байгаа орчинд хохирол учруулахгүй байх, ашигласан талбайг сэргээх.

7 дугаар зүйл. Гэрээлэгчид эдэлбэр олгох

1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулан эдэлбэр газрын зөвшөөрлийг орон нутгийн эрх барих байгууллага, уурхайн эдэлбэрийн зөвшөөрлийг Засгийн газар тус тус олгоно.

2. Зөвшөөрсөн эдэлбэрийн хилээс гадна газрын тос хайх, олборлохыг хориглоно.

8 дугаар зүйл. Гэрээлэгчийн үйл ажиллагаа явуулах хугацаа

1. Эрэл, хайгуулын ажил явуулах хугацаа 5 хүртэл жил байна.

2. Газрын тосны хэрэг эрхлэх байгуулалта нь гэрээлэгчтэй нөхцөлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр эрэл, хайгуулын ажлын хугацааг 2 удаа тус бүр 2 жилээр сунгаж болно.

3. Газрын тосны ордыг ашиглах хугацаа нь газрын тос олборлохыг зөвшөөрөх тухай газрын тосны хэрэг эрхлэх байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 20 хүртэл жил байж болно.

4. Гэрээлэгч нь боловсруулах үйлдвэр барих, шингэн тос, байгалийн хий тээвэрлэх хоолой тавих зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц шинээр барьж байгуулах тохиолдолд орд ашиглах хугацааг газрын тосны хэрэг эрхлэх байгууллага хоёр удаа тус бүр 5 жилээс нлүүгүй хугацаагаар сунгаж болно.

9 дүгээр зүйл. Гэрээлэгчид ногдуулах төлбөр, татвар

1. Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөрийг улсад төлнө. Төлбөрийн хэмжээг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ажиллаж байгаа тохиолдолд газрын тос олборлосны төлбөрийг бүтээгдэхүүн хуваах тусгаар ороулж болно.

2. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчид БНМАУ-ын хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр татвар ногдуулна.

3. Газрын тос олборлосны төлбөр, татвар төлөх хэлбэрийг гэрээлэгч болон газрын тосны хэрэг эрхлэх байгууллагын саналыг үндэслэн БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

10 дугаар зүйл. Бүтээгдэхүүн хуваах

1. Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөр болон зардалаа нөхөх хэсгийг нийт олборлолтоос хасаад үлдсэн бүтээгдэ-

хүүнийг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай хуваана. Бүтээгдэхүүн хуваах хувь хэмжээг хоногт гаргаж байгаа газрын тосны хэмжээтэй уялдуулан тохиролцож газрын тосны тухай гэрээнд тодорхойлон заана.

2. Гэрээлэгч хуваарьт газрын тосоо экспортлож болно.

3. Газрын тосны хэрэг эрхлэх байгууллага нь гэрээлэгчвэс түүний хуваарьт газрын тосыг БНМАУ-ын дотоодын хэрэгцээнд нийлүүлэхийг хүсэх эрхтэй.

11 дугаар зүйл. Зардал нөхөх

Гэрээлэгч нь газрын тосыг үр ашигтай олборлож эхэлсэн нөхцөлд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулсан зардлаа нөхөж авах эрхтэй. Зардал нөхөхөд тухайн гэрээлэгчийн жилд олборлосон нийт газрын тосны 40 хүртэл хувийг зарцуулна.

12 дугаар зүйл. Гаалийн татвараас чөлөөлөх

БНМАУ-ын гаалийн хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дор дурдсан тохиолдолд гаалийн татвараас чөлөөлнө:

1) БНМАУ-ын хилээр газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж, материал, түүхий эд оруулах;

2) газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан түр хугацаагаар БНМАУ-д оруулсан тоног төхөөрөмжийг буцаан гаргах;

3) гэрээлэгчийн хуваарьт газрын тосыг БНМАУ-ын нутаг дэвсгэрээс гаргах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Маргааныг хянан шийдвэрлэх, хууль тогтоомж
өрчигчдөд хүлээлтэх хариуцлага*

13 дугаар зүйл. Маргааныг хянан шийдвэрлэх

1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүссэн эд хөрөнгийн маргааныг газрын тосны тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол БНМАУ-ын шүүх БНМАУ-ын хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

2. Газрын тосны тухай гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг хүчингүй болгох зэрэг гэрээтэй холбогдох асуудлаар үүссэн маргааныг талууд хүсвэл НҮБ-ын Олон улсын худалдааны эрх

зүйн байгууллагын дүрмийн дагуу зохицуулан шийдвэрлүүлж болно.

14 дүгээр зүйл. Хуулийн хариуцлага

1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг дур мэдэн буюу зөвшөөрөлгүй явуулсан бол тухайн этгээдийн уг үйл ажиллагаа явуулахад хэрэглэсэн тоног төхөөрөмж, эд хөрөнгө, олборлосон бүтээгдэхүүн, орлогыг БНМАУ-ын эрх бүхий байгууллага хураан авч улсын орлогод шилжүүлнэ.

Харин уг үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй байвал БНМАУ-ын шүүх шийдвэрлэнэ.

2. Гэрээлэгч талууд нь энэ хууль болон БНМАУ-ын холбогдох бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгууллага, иргэдэд хохирол учруулсан бол БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

3. Гэрээлэгч талууд нь гэрээний үүргийг зөрчсөнөөс учирсан хохирлыг гэрээнд буюу БНМАУ-ын иргэний хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай тал нь нөхөн төлнө.

15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилсан өдрөөс дагаж мөрдөнө.

БНМАУ-ын Бага Хуралд
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хуралд
парийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 1 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан «БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль», «Хууль, хуулийн заалтууд хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хууль»-ийг тус тус зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

байгууллагын дүрмийн дагуу зохицуулан шийдэрлүүлж

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн нийгэм зорил

БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн зорилт нь иргэдтэд хөдөлмөрийн гэрээ байгуулж хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэхтэй ; богдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. БНМАУ-ын хөдөлмөрийн хууль тогтоогох

БНМАУ-ын хөдөлмөрийн хууль тогтоомж нь БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гарга БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулиар зохицуулах харилцаа

БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулиар дор дурдсан харилцаа зохицуулана:

1) улс, хоршоолол, олон нийт, хувийн үйлдвэрийн газар байгууллагын захиргаа, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэн хоорондын хөдөлмөрийн харилцаа;

2) БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бусад тус улсын нутаг дэвсгэрт байгаа хамтын болон гадаадын үйлдвэрийн газар, байгууллагын захиргаа, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэн хоорондын хөдөлмөрийн харилцаа;

3) иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр үүссэн харилцаа (хөдөлмөрийн гэрээнд оролцогч талуудыг энэ хуульд цаашид «захиргаа», «ажилтан» гэж нэрлэнэ).

4 дүгээр зүйл. Захиргааны үндсэн эрх, үүрэг

1. Захиргаа нь БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх, ажилтнаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаарддаг, энэ хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх эрхтэй.

2. Захиргаа нь ажилтны хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлөөр хангах хөдөлмөрийн үр дүнд тохирсон хөлс олгох, хэлэлцээ хийж хамтын гэрээ байгуулах, ажилтан БНМАУ-ын хууль тогтоомжид заасан бусад эрхээ эдлэх нөхцөлийг хангах үүрэгтэй.

аар зүйл. Ажилтны үндсэн эрх, үүрэг

Ажилтан мэргэжил, авьяас сонирхолынхоо дагуу ажил сонгох, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлөөр хангагдах, хөдөлмөрийн үр дүнд тохирсон хөлс авах, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх замаар эрх ашгаа хамгаалах, БНМАУ-ын хууль тогтоомжид заасны дагуу амрах, тэтгэвэр, тэтгэмж авах, бусад хөнгөлөлт эдлэх эрхтэй.

2. Ажилтан нь хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахих, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

6 дугаар зүйл. Хөдөлмөрийн харилцаанд хязгаарлал, давуу тал тогтоохыг хориглох

Хөдөлмөрийн харилцаанд нийгмийн гарал, байдал, арьсны өнгө, яс үндэс, эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, эд хөрөнгийн байдал, улс төрийн үзлээр ялгаварлан шууд буюу шууд бус аливаа хязгаарлал, давуу тал тогтоохыг хориглоно.

ХОЕРДУГААР БҮЛЭГ

Хамтын гэрээ

7 дугаар зүйл. Хамтын гэрээ байгуулах

1. Хамтын гэрээний зорилт нь хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж баталгаажуулахад оршино.

2. Хамтын гэрээг нэг талаас захиргаа, нөгөө талаас нийт ажилтны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллага, хэрэв тийм байгууллага байхгүй бол хамт олны төлөөлөгчийн (цаашид «үйлдвэрчний эвлэл» гэх) хооронд хэлэлцээ хийж байгуулна.

3. Хамтын гэрээний хугацаа, түүнийг байгуулах, хэрэгжүүлэх, гэрээний биелэлтэд хяналт тавих журмыг гэрээнд оролцогч талууд тогтооно.

4. Хамтын гэрээ нь уг гэрээнд өөрөөр заагаагүй бол оролцогч талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5. Хамтын гэрээ нь байгууллагын нийт ажилтанд хамаарна.

6. БНМАУ-ын хууль тогтоомжид харшлалсан хамтын гэрээний заалтыг хүчингүйд тооцно.

8 дугаар зүйл. Хамтын гэрээгээр зохицуулах харилцаа

1. Хамтын гэрээгээр дор дурдсан харилцааг зохицуулна:

1) хөдөлмөрийн хөлсний хуваарилалтыг боловсронгуй болгох, хөдөлмөрийн хөлсэнд зарцуулах хөрөнгийн хэмжээг тогтоох;

2) нийгэм, ахуйн хөнгөлөлт үзүүлэх;

3) хөдөлмөр хамгаалаа, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах;

4) ажил, амралтын цагийн горим тогтоох;

5) ажилтанд мэргэжил олгох, мэргэшлийг нь дээшлүүлэх;

6) энэ хуулиар шууд зохицуулаагүй хөдөлмөрийн харилцааны бусад асуудал.

2. Хамтын гэрээгээр БНМАУ-ын хууль тогтоомжид зааснаас илүү хөнгөлөлтийг байгууллагын хөрөнгөөс олгохоор тогтоож болно.

9 дүгээр зүйл. Хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

Хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг уг гэрээг анх байгуулсан журмын дагуу оролцогч талууд тохиролдож шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл. Хамтын гэрээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага

Хамтын гэрээ биелүүлээгүйгээс үүсэх хариуцлагыг уг гэрээнд харилцан тохиролцсоны дагуу болон БНМАУ-ын хууль тогтоомжид зааснаар хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн гэрээ

11 дүгээр зүйл. Хөдөлмөрийн гэрээ

Нэг талаас ажиглан хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахиж, тодорхой мэргэжил, мэргэшил, албан тушаалын үүрэгт ажил гүйцэтгэх, нөгөө талаас захиргаа ажиглан БНМАУ-ын хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээнд заасны дагуу болон өөртэй нь тохиролцсоноор хөдөлмөрийн хөлс олгох, хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг авсан хэлэлцээрийг хөдөлмөрийн гэрээ гэнэ.

12 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээ байгуулах

1. Хөдөлмөрийн гэрээг захиргаа болон ажиглан харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр байгуулна.

Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажла гүйцэтгүүлэхийг хориглоно.

2. Хөдөлмөрийн гэрээг хугацаатай буюу хугацаагүй байгуулна.

3. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусахаас өмнө захиргаа, ажилтан харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хугацааг сунгаж болно.

4. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусахад захиргаа, ажилтны аль нэг нь түүнийг цуцлах санал таниагүй бөгөөд ажилтан ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа бол уг гэрээг гэрээнд заасан хугацаагаар сунгагдсанд тооцно.

5. БНМАУ-ын хууль тогтоомж болон хамтын гэрээнд харшилсан хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хүчингүйд тооцно.

13 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил гүйцэтгүүлэхийг хориглох

Захиргаа нь энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил гүйцэтгэхийг ажилтнаас шаардахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Ажил, албан тушаалыг хэвээр хадгалах, урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд өгүүлж авах

1. Ажилтны ажил, албан тушаалыг дор дурдсан тохиолдолд хэвээр хадгална:

1) төрийн байгууллагад сонгуульд үүрэг түр хугацаагаар (3 сар хүртэл) гүйцэтгэж байгаа;

2) эвэлжийн амралттай байгаа;

3) эмнэлгийн шинжилгээ хийлгэх буюу донорын үүрэг гүйцэтгэж байгаа, эмчийн магадлагаагаар болон захиргааны зөвшөөрлөөр чөлөөтэй байгаа;

4) жирэмсний, амаржсаны амралттай байгаа;

5) хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан ажил хаялтад оролцож байгаа;

6) БНМАУ-ын хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

2. Захиргаа, ажилтан харилцан тохиролцож ажил, албан тушаалыг хэвээр хадгалах бусад тохиолдлыг тогтоож болно.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа хугацаанд энэ хуулийн 18 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 4 дэх заалт хамаарахгүй.

4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болж ажлаас халагдсан ажилтан эдгэрснийхээ дараа нэг сарын дотор эргэж ирсэн тохиолдолд уг ажилтныг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд өгүүлэн авна. Хэрэв

тйим боломжгүй бол түүнтэй тохиролцсоны үндсэн дээр адилчарны өөр ажил, албан тушаалд авч ажиллуулана.

15 дугаар зүйл. Ажил, албан тушаал хавсрах, хослон ажиллах, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэх

1. Ажилтан үндсэн ажлынхаа чөлөөт цагаар өөрийн буюу бүсэд байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр өөр ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэж болно.

Хавсран гүйцэтгэж болохгүй ажил, албан тушаалын жагсаалтыг БНМАУ-ын Засгийн газар батална.

2. Ажилтан өөрийн байгууллагад ажлын цагтаа багтаан хөдөлмөрийн гэрээнд заасан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжл хослон ажиллаж болно.

3. Захиргаа ажилтантай тохиролцсоны дагуу үндсэн ажлын нь зэрэгцээ эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлж болно.

16 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагаар өөр ажилд түр шилжүүлэх

Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг арилгах зэрэг үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлага гарвал захиргаа нь ажилтныг хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд 45 хоног хуртал хугацаагаар шилжүүлж болно. Энэ тохиолдолд хөдөлмөрийн хөлсийг гүйцэтгэсэн ажилд нь тохируулан олгох боловч урьд авч байсан дундаж хөлсийг бууруулж болохгүй.

17 дугаар зүйл. Сул зогсолтын үед өөр ажилд түр шилжүүлэх

Сул зогсолтын үед ажилтныг байгууллага дотроо хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд, эсхүл тухайн орон нутагт байгаа өөр байгууллагад өөртэй нь тохиролцсон хугацаагаар шилжүүлж болно.

18 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох үндэслэл

1. Хөдөлмөрийн гэрээ дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

1) хоёр тал хэлэлцэн тохирсон;

2) ажилтан санаачилсан, эсхүл тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан;

3) захиргаа санаачилсан;

4) хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж цаашид сунгагдахгүй болсон;

5) ажилтан жинхэнэ хугацаат цэргийн албанд татагдсан;

6) ажилтан гэмт хэрэг үйлдсэний улмаас уг ажлаа үргэлжлүүлэн хийх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

7) хөдөлмөрийн гэрээ цуцлахыг БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллага шаардсан.

2. Байгууллагын харьяалал, захиргаа өөрчлөгдсөн нь хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болохгүй.

19 дүгээр зүйл. Хөдөлмөрийн гэрээг ажилтны санаачилгаар цуцлах

1. Ажилтан нь ажлаас халагдах тухай өргөдлөө захиргаанд өгснөөс хойш нэг сар өнгөрмөгц хөдөлмөрийн гэрээг цуцлагдсанд тооцно.

2. Хүндэтгэн үзэх шалтгаантай, эсхүл захиргаатай тохиролцсон бол хөдөлмөрийн гэрээг энэ зүйлд заасан хугацаанаас өмнө цуцалж болно.

20 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээг захиргааны санаачилгаар цуцлах

1. Хөдөлмөрийн гэрээг дор дурдсан үндэслэлээр захиргааны санаачилгаар цуцалж болно:

1) байгууллага татан буугдсан, орон тоо нь хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн;

2) мэргэжил, чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон;

3) хөдөлмөрийн сахилгыг удаа дараа зөрчсөн;

4) БНМАУ-ын Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан болзол хангасан;

5) мөнгө буюу эд хөрөнгө гардан хариуцсан ажилтан захиргааны итгэлийг алдагдуулсан буруутай үйлдэл нь тогтоогдсон.

2. Ажлаас буруу халагдсан нь нотлогдон шүүхийн шийдвэрээр ажилд нь эгүүлэн тогтоох болсон тохиолдолд уг ажил, албан тушаалд шинээр орсон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж бололцооны дагуу өөр ажил олж өгнө.

3. Хөдөлмөрийн гэрээг энэ зүйлийн нэг дэх хэсгийн 1-д заасан үндэслэлээр цуцлах тухай ажилтанд нэг сарын өмнө урьдчилан мэдэгдэнэ.

4. Хөдөлмөрийн гэрээг энэ хуулийн 14 дүгээр зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан тохиолдолд захиргааны санаачилгаар цуцлахыг хориглоно.

5. Захиргаа нь энэ зүйлийн нэг дэх хэсгийн 1, 2-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтныг хөдөлмөрийн захад үртгүүлж, БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу хураамж төлнө.

21 дүгээр зүйл. Ажлаас халагдсаны тэтгэмж

Захиргаа нь ажлаас халагдсан ажилтанд энэ хуулийн 18 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6, 20 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 3, 5-д зааснаас бусад тохиолдолд нэг сараас доошгүй хугацааны дундаж хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно.

22 дугаар зүйл. Ажил, албан тушаал эрхлэхийг түр болнуулах

БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллага шаардсан бол ажилтныг тухайн ажил, албан тушаал эрхлэхийг түр болнуулж хөдөлмөрийн хөлс олгохыг зогсооно.

23 дугаар зүйл. Хөдөлмөрийн дэвтэр

1. Хөдөлмөрийн дэвтэр нь ажилтны хөдөлмөрийн үйл ажиллагааны үндсэн баримт бичиг мөн.
2. Захиргаа нь ажилтны ажил гүйцэтгэж эхэлсэн өдрөөс хөдөлмөрийн дэвтэр хөтөлнө.

24 дүгээр зүйл. Ажлаас халах, ажил хүлээлцэх тухай

1. Захиргаа нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажил хүлээлцэх хугацааг тогтоож уг хугацааг ажлаас халах тухай шийдвэрт заана.
2. Ажилтан ажил хүлээлцэн өгсөн сүүлчийн өдрийг ажлаас халагдсан өдөр гэж үзнэ.
3. Захиргаа нь ажилтанд ажлаас халагдсаны тэтгэмж, хөдөлмөрийн дэвтрийг халагдсан өдөрт нь өгөх үүрэгтэй.
4. Захиргаа нь ажилтны хүсэлтээр ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаал, хөдөлмөрийн хөлсний тухай тодорхойлолыг гаргаж өгөх үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ажил, амралтын цаг

25 дугаар зүйл. Ажлын цаг

1. Долоо хоногийн ажлын цаг нь 46-гаас илүүгүй байна.
2. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг байна.
3. Хамтын гэрээнд оролцогч талууд харилцан тохиролцсоны дагуу ажлын өдрийн үргэлжлэлийг долоо хоногийн ажлын цагт багтаан өөрчлөн тогтоож болно.

4. Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралтын хугацаа 12 цагаас доошгүй байвал зохино.

26 дугаар зүйл. Ажлын цагийг богиносгох

1. Долоо хоногийн ажлын цаг нь 14, 15 насны ажилтанд 30 цагаас, 16-гаас 18 хүртэлх насны ажилтанд 36 цагаас илүүгүй байна.

2. Захиргаа хөдөлмөрийн стандартыг баримтлан хүнд, хортой, халуун болон газрын доорх нөхцөлийг тогтоож, түүнийг үндэслэн ажилтны ажлын цагийг богиносгох үүрэгтэй.

3. Ажилтны ажлын цагийг эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн дагуу богиносгож болно.

27 дугаар зүйл. Шөнийн цаг

1. Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацааг шөнийн цагт тооцно.

2. Энэ зүйлд заасан хугацаанд ажлын цаг нь 7-гоос илүүгүй байна.

28 дугаар зүйл. Ажлын бүтэн бус өдөр, долоо хоног тогтоох

1. Захиргаа нь ажилтантай тохиролцон ажлын бүтэн бус өдөр, долоо хоногийг тогтоож болно. Энэ тохиолдолд ажилласан цаг буюу хийсэн ажилд нь тохирсон хөдөлмөрийн хэсэг олгоно.

2. Ажлын бүтэн бус өдөр, долоо хоног тогтоосон нь ажилтанд ээлжийн амралт олгох, ажилласан хугацааг тооцох зэрэг хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэглэхэд хязгаарлал болохгүй.

29 дүгээр зүйл. Ажлын цагийг нэгтгэн бодох

Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй бол ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэглэж болно. Энэ тохиолдолд нэгтгэн бодсон цаг нь тооцоот хугацаанд ногдох ажлын цагийн нийлбэрээс хэтэрч болохгүй.

30 дугаар зүйл. Илүү цагаар ажиллуулахыг хязгаарлах

1. Энэ хуульд заасан үндэслэлийн дагуу хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг захиргааны санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсан гэж үзнэ.

2. Дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг захиргааны санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно:

1) улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх;

2) байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг нэн даруй арилгах;

3) нийтийн усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүч, тээвэр, холбооны хэвийн ажиллагааг алдагдуулсан гэмтлийг арилгах;

4) урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай хийхгүй бол байгууллаагын буюу түүний нэгжийн хэвийн ажиллагаанд саад учрууаж болзошгүй хойшуулагшгүй ажил гүйцэтгэх.

3. Ажилтныг хоёр ээлжинд дараалан ажиллуулахыг хориглоно.

4. Ажилтныг дараалсан хоёр өдөрт илүү цагаар ажиллуулах хугацаа 4 цагаас хэтэрч болохгүй.

31 дүгээр зүйл. Амрах, хооллох завсарлага

1. Ажилтанд амарч, хооллоход нь зориулан завсарлага олгоно. Завсарлага эхлэх, дуусах цагийг хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно.

2. Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ажилтай ажилтныг захиргаа хооллох бололцоогоор хангана.

32 дугаар зүйл. Нийтээр амрах баярын өдөр

1. Дор дурдсан баярын өдрүүдэд нийтээр амарна:

1) шинэ жил—нэгдүгээр сарын 1;

2) билгийн улирлын хаврын тэргүүн сар—цагаан сарын шинийн 1, 2;

3) олон улсын эмэгтэйчүүдийн өдөр—гуравдугаар сарын 8;

4) Монголын ардын хувьсгалын ойн баяр—долдугаар сарын 11, 12, 13;

5) Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхагласан өдөр—арван нэгдүгээр сарын 26.

2. Нийтээр амрах баярын өмнөх ажлын өдрийн үргэлжлэл 6 цагаас илүүгүй байна.

33 дугаар зүйл. Долоо хоног бүрийн амралт

1. Ням гаригт нийтээр амарна.

2. Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан ням гаригт амрах боломжгүй ажилтныг долоо хоногийн өөр өдөр амруулна.

3. Хоёр долоо хоногийн хоорондох тасралтгүй амралтын хугацаа 42 цагаас бага байж болохгүй.

34 дүгээр зүйл. Нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулахыг хязгаарлах

1. Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр захиргааны санаачилгаар ажиллуулахыг хориглоно:

1) энэ хуулийн 30 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт заасан тохиолдолд;

2) тасралтгүй ажиллагаатай үйлдвэрлэл, хүн амын үйлчилгээний болон хойшуулшгүй засвар, ачиж буулгах ажил гүйцэтгэх.

2. Захиргаа нийтээр амрах баярын буюу долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсан ажилтныг түүнтэй тохироцсоноор өөр өдөр амруулах, эсхүл уг амралтыг ээлжийн амралттай нь хамтатган олгож болно. Ийм боломжгүй бол хөдөлмөрийн хөлсийг энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

35 дугаар зүйл. Ээлжийн амралт, түүний хугацаа

1. Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүнэ.

2. Ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 21 өдөр байна.

3. Ажилтны ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл амралт олгоно:

1) хөдөлмөрийн хэвийн нөхцөлд:

6—10 жилд	3 өдөр
11—15 жилд	5 өдөр
16—20 жилд	7 өдөр
21—25 жилд	9 өдөр
26—31 жилд	11 өдөр
32-оос дээш	14 өдөр

2) хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд:

1—4 жилд	5 өдөр
5—8 жилд	7 өдөр
9—12 жилд	9 өдөр

3) газрын дор:

1—4 жилд	10 өдөр
5—6 жилд	14 өдөр
7—8 жилд	16 өдөр
9—10 жилд	18 өдөр

4. Нэмэгдэл амралтыг ажлын өдрөөр тооцно.

5. 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн амралтын хугацаа ажлын 30 өдөр байна.

6. Зарим ажилтны нэмэгдэл амралтын хугацааг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

36 дугаар зүйл. Чөлөө олгох

Захиргаа нь ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгож болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн хөлс, баталгаат болон нөхөх олговор

37 дугаар зүйл. Хөдөлмөрийн хөлсний зохицуулалт

1. Ажилтны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

2. Хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож байна.

3. Захиргаа нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн бололцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний сүлжил, жишгийг тогтооно.

4. Ажилтны хөдөлмөрийн хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно.

5. Ажилтны буруу биш шалтгаанаар хөдөлмөрийн хөлс буурахад хүрвэл БНМАУ-ын Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байж болохгүй.

38 дугаар зүйл. Тариф-мэргэшлийн лавлах

1. Мэргэжил, албан тушаалын тариф-мэргэшлийн лавлах зохиох аргачлал, мэргэжил, албан тушаалын нэрийн нэгдсэн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал харнуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргана.

2. Захиргаа нь энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан аргачлал, жагсаалт, тухайн ажлын шинж чанар, түвэгшлийг үндэслэн мэргэжил, албан тушаалын тариф-мэргэшлийн лавлахыг баталж мөрдөнө.

39 дүгээр зүйл. Нэмэгдэл хөлс

1. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл хөлсний доод хэмжээг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

2. Мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл хөлсний хэмжээг захиргаа, харин мэргэжил хөслөн ажилласны болон

эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсний хөлсний хэмжээг захиргаа ажилтантай тохиролцон тогтооно.

40 дүгээр зүйл. Илүү цагаар ажилласны хөлс

Илүү цагаар ажилласны хөлсийг хоёр дахин нэмэгдүүлэн олгоно.

41 дүгээр зүйл. Нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажилласны хөлс

1. Нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол хөлсийг хоёр дахин нэмэгдүүлэн олгоно.

2. Нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулсан бол хөлсийг дээрх нэмэгдэлгүйгээр олгоно.

42 дүгээр зүйл. Бүтээлийн норм биелүүлээгүй үеийн хөлс

1. Ажилтан өөрийн буруу биш шалтгаанаар бүтээлийн нормоо биелүүлээгүй бол гүйцэтгэсэн ажлын хөлс дээр нь урьд авч байсан дундаж хөлсний зөрүүг нөхөн олгоно.

2. Ажилтан өөрийн буруугаас нормоо биелүүлээгүй бол гүйцэтгэсэн ажилд нь тохирсон хөлс олгоно.

43 дүгээр зүйл. Гологдол гаргасан үеийн хөлс

1. Ажилтан өөрийн буруу биш шалтгаанаар гологдол гаргасан бол тарифт хөлсийг 100 хувь олгоно.

2. Ажилтан өөрийн буруугаас гологдол гаргасан бол гүйцэтгэсэн ажлын үр дүнгийнх нь хэрэгцээ хангах байдлыг харгалзан тарифт хөлсийг бууруулж олгоно.

3. Ажилтан өөрийн буруугаас бүрэн гологдол гаргасан бол хөлс олгохгүй.

44 дүгээр зүйл. Сул зогсолтын үеийн хөлс

1. Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол тарифт хөлсийг 100 хувь олгоно.

2. Ажилтны буруугаас гарсан сул зогсолтын хугацаанд хөлс олгохгүй.

3. Сул зогсолтын үед өөр ажилд шилжсэн ажилтанд гүйцэтгэсэн ажилд нь тохируулан хөлс олгох боловч урьд авч байсан дундаж хөлсний хэмжээнээс бага байж болохгүй.

4. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөр ажилд шилжихээс татгалзсан ажилтанд хөлс олгохгүй.

45 дугаар зүйл. 18 насанд хүрээгүй ажилтны хөдөлмөрийн хөлс

18 насанд хүрээгүй ажилтны хөдөлмөрийн хөлсийг цагаар буюу хийснээр нь бодож ажлын өдрийн хорогдуулсан цагт нь ногдох тарифт хөлсийг нөхөн олгоно.

46 дугаар зүйл. Ажил хүлээлцэх үеийн хөдөлмөрийн хөлс

1. Ажил хүлээлцэх үеийн хөдөлмөрийн хөлсийг ажилтны ажиллаж байсан байгууллага олгоно.

2. Захиргааны буруугаар ажил хүлээлцэх хугацаа хэтэрвэл уул хугацааны хөлсийг ажилтанд олгоно.

Халагдаж байгаа хүний буруугаар ажил хүлээлцэх хугацаа хэтэрвэл уул хугацааны хөлсийг олгохгүй.

47 дугаар зүйл. Хөдөлмөрийн хөлс олгох хугацаа

1. Ажилтны хөдөлмөрийн хөлсийг сард хоёроос доошгүй удаа тогтоосон өдөр олгоно.

2. Ажилтанд хүсэлтээр нь хөдөлмөрийн хөлсний урьдчилгаа олгож болно.

48 дугаар зүйл. Хөдөлмөрийн хөлсний тухай мэдэгдэх

Захиргаа нь хөдөлмөрийн хөлсний хэлбэр, хэмжээг өөрчлөх, шинээр мөрдүүлэх тухай нэг сараас доошгүй хугацааны өмнө нийт ажилтанд мэдэгдэнэ.

49 дүгээр зүйл. Хөдөлмөрийн хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах

1. Ажилтны хөдөлмөрийн хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно:

1) дараа тайлан гаргахаар мөнгө авсан;

2) ажилтны нэг сарын дундаж хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай захиргааны шийдвэр гарсан;

3) БНМАУ-ын хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

2. Тооцооны алдаанаас бусад шалтгаанаар илүү олгосон мөнгийг ажилтнаас суутган авч болохгүй.

3. Ажилтны нэг сарын хөдөлмөрийн хөлснөөс хийх нийт суутгалыг (орлогын албан татварыг оролцуулахгүйгээр) хөдөлмөрийн хөлсний 20 хувиас, харин хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон хэд хэдэн суутгал нэгэн зэрэг хийх бол хөдөлмөрийн хөлсний 50 хувиас хэтрүүлж болохгүй.

50 дугаар зүйл. Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтанд олгох хөлс, тэтгэмж

Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан то-

хиолдолд ажилтанд дундаж хөлс, хэрэв БНМАУ-ын хууль тогтоомжид тусгайлан заасан бол тэтгэмж олгоно.

51 дүгээр зүйл. Өөр орон нутагт ажиллахаар шилжих үеийн нөхөх олговор

Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор нэг сум, хорооноос нөгөө сум, хороонд сонгогдсон буюу томилогдсон ажилтанд унаалга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст унаалга, ачаа тээшийн зардлыг хүлээн авч байгаа байгууллага олгоно.

52 дугаар зүйл. Хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн нөхөн олговор

Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ажилдаа ирж чадаагүй ажилтанд тарифт хөлсний 50 хувьтай тэнцэх хэмжээний нөхөх олговор өгнө. Харин нийм гамшиг, саатлын хор уршгийг арилгахад биеэр оролцсон ажилтанд тарифт хөлснийг 100 хувь олгоно.

53 дугаар зүйл. Ажлын цагийг богиносгосон үеийн хөлс

Энэ хуулийн 26 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасны дагуу ажлын цагийг нь богиносгосон ажилтанд зургаан сарын хугацаанд түүний урьд авч байсан дундаж хөлснийг олгоно.

54 дүгээр зүйл. Ажилтныг эрүүл мөндөд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн үеийн хөдөлмөрийн хөлс

Энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу өөр ажилд шилжүүлсэн ажилтны хөдөлмөрийн хөлс буурахад хүрвэл зургаан сарын хугацаанд түүний урьд авч байсан дундаж хөлснийг олгоно.

55 дугаар зүйл. Буруу халсан буюу шилжүүлсэн үеийн хөлс

1. Буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн ажилтныг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол түүнд ажилгүй байсан бүх хугацаанд нь урьд авч байсан дундаж хөлснийг, хэрэв бага хөлстэй ажил хийж байсан бол зөрүүг нь нөхөн олгоно.

2. Ажлаас халсан шалтгааныг хөдөлмөрийн дэвтэрт буруу бичсэн нь ажилтан ажилд ороход саад болсон буюу бага хөлстэй ажилд ороход хүргэсэн бол түүнд ажилгүй байсан бүх хугацаанд урьд авч байсан дундаж хөлснийг, хэрэв бага хөлстэй ажил хийж байсан бол зөрүүг нь нөхөн олгоно.

3. Захиргаа ажлаас халагдсан ажилтны хөдөлмөрийн дэвтрийг хугацаанд нь өгөлгүй саатуулснаас уг ажилтан ажилгүй

байсан бол хүлээлгэсэн бүх хугацаанд урьд авч байсан дундаж хөлсийг олгоно.

4. Энэ зүйлд заасан хөлсийг ажлаас халсан байгууллагын захиргаа олгож, үүний улмаас байгууллагад учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх боловч тэр нь уг этгээдийн гурван сарын хөлсний хэмжэвнээс хэтрэхгүй байвал зохино.

56 дугаар зүйл. Өртөг, зардалг нөхөх

Үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг зайлшгүй хангах шаардлагын улмаас ажилтан хувийнхаа техник, багаж хэрэгслийг захиргаатай харилцан тохиролцсон үндсэн дээр ашигласан тохиолдолд тэдгээрийн элэгдлийн өртөг, бусад зайлшгүй зардалг БНМАУ-ын хууль тогтоомжид буюу гэрээнд заасны дагуу захиргаа нөхөн олгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага

57 дугаар зүйл. Хөдөлмөрийн дотоод журам

1. Захиргаа нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдөнө.

2. Хөдөлмөрийн дотоод журамд байгууллагын хөдөлмөр зохион байгуулалт, захиргаа болон ажилтны эрх, үүрэг, хариуцлага, ажилтныг урамшуулах нөхцөлийг тусгана.

3. Зарим салбарт төрийн зохих дээд байгууллагаас баталсан сахилгын тусгай дүрэмтэй байж болно.

58 дугаар зүйл. Хөдөлмөрийн сахилгын шийтгэл

1. Захиргаа хөдөлмөрийн сахилга зөрчсөн ажилтанд дор дурдсан сахилгын шийтгэлийг шийдвэр (тушаал, тогтоол, захирамж) гаргаж оногдуулна:

1) сануулах;

2) хөдөлмөрийн хөлсийг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

3) ажлаас халах.

2. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг сар, зөрчил гаргаснаас хойш зургаан сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

3. Сахилгын шийтгэлийг давхардуулан оногдуулж болохгүй.

4. Сахилгын шийтгэл оногдуулсан тухай хөдөлмөрийн дэвтэрт тэмдэглэхийг хориглоно.

5. Сахиагын шийтгэл оногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахиагын шийтгэлгүйд тооцно.

59 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

1. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад өөрийн буруугаас хохирол учруулсан ажилтанд бусад шийтгэл (сахиагын, захиргааны, эрүүгийн) оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

2. Хохирлын хэмжээг шууд учирсан жинхэнэ хохирлоор тодорхойлох бөгөөд орох байсан орлогыг хохиролд оруулан тооцохгүй.

3. Үйлдвэрлэл-аж ахуйн туршиат, тохируулгаас шалтгаалж гарсан зайлшгүй хохирлыг ажилтнаар төлүүлж болохгүй.

4. Захиргаа нь хариуцуулсан эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах шаардлагатай нөхцөлийг бүрдүүлээгүйгээс шалтгаалж учирсан хохирлыг ажилтнаар төлүүлж болохгүй.

60 дугаар зүйл. Эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага

Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад өөрийн буруугаас хохирол учруулсан ажилтан энэ хуулийн 61 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээх бөгөөд тэр нь уг ажилтны нэг сарын дундаж хөлснөөс хэтэрч болохгүй.

61 дүгээр зүйл. Эд хөрөнгийн бүрэн хариуцлага

1. Ажилтан дор дурдсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ:

1) ажилтны байгууллагад хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэрэг болохыг зохих журмаар тогтоосон;

2) хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан ажилтанд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр БНМАУ-ын хууль тогтоомжид заасан;

3) эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх тухай энэ хуулийн 62 дугаар зүйлийн дагуу захиргаатай гэрээ байгуулсан ажилтан хариуцсан эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг дутагдуулсан;

4) дараа тайлан гаргахаар итгэмжлэл буюу бусад баримт бичгээр хүлээн авсан эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг хугацаанд нь эгүүлж төлөөгүй;

5) эд хариуцагч биш боловч эрхэлсэн ажилтай нь шууд холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаар тавьж олгосон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл зэрэг эд хөрөнгийг үрэгдүүлсэн;

6) согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн

болон хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаагүй үедээ байгуулла-
лагад хохирол учруулсан.

2. Зарим төрлийн эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг ашиглан
шамшигдуулсан, дутагдуулснаас байгууллагад учирсан хохирлыг
төлүүлэх өөр журмыг гагцхүү БНМАУ-ын хууль тогтоомжоор
тогтоож болно.

62 дугаар зүйл. Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ

1. Захиргаа эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг хадгалах, бо-
ловсруулах, худалдах, олгох, тээвэрлэх болон тэдгээрийг үйлд-
вэрлэлд хэрэглэхтэй шууд холбоотой ажил гүйцэтгэж байгаа
18 насанд хүрсэн ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын
тухай гэрээг бичгээр байгуулна.

2. Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж болох ажил,
албан тушаалын жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан
төрийн захиргааны төв байгууллага батална.

63 дугаар зүйл. Байгууллагад учирсан хохирлын хэмжээг
тодорхойлох

1. Байгууллагад учирсан хохирлын хэмжээг эд хөрөнгө, үнэ
бүхий зүйлийн нягтлан бодох бүртгэлийн буюу балансын өрт-
гөөс зохих нормоор бодсон эзэгдлийг хасаж, жинхэнэ гарсан
алдагдлаар тодорхойлно.

2. Эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг ашиглан шамшигдуулсан,
санаатайгаар устгасан, гэмтээсэн үед хохирлын хэмжээг ту-
хайн үеийн үнээр тодорхойлно.

3. Хэд хэдэн ажилтны буруугаар учирсан хохирлын хэмжээг
тус бүрийн гэм буруугийн хэр хэмжээ, эд хөрөнгийн хариуцла-
гын төрлийг харгалзан хүн нэг бүрээр тодорхойлно.

64 дүгээр зүйл. Байгууллагад учруулсан хохирлыг нөхөн
төлүүлэх

1. Ажилтны нэг сарын дундаж хөлснөөс хэтрэхгүй хэмжээ-
ний хохирлыг захиргааны шийдвэрээр хөдөлмөрийн хөлснөөс нь
суутгаж нөхөн төлүүлнэ. Суутгал буюу түүний хэмжээг ажилтан
эс зөвшөөрвөл гомдлоо хөдөлмөрийн маргаан таслах комисст
гаргаж болно.

2. Ажилтны нэг сарын дундаж хөлснөөс хэтэрсэн хохирлыг
нөхөн төлүүлэх тухай шүүхэд нэхэмжлэл гаргана.

3. Захиргаа ажилтны хөдөлмөрийн хөлснөөс хууль бусаар
суутгал хийсэн бол уг суутгасан мөнгийг эгүүлэн олгох тухай
гомдлыг хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага хянан
шийдвэрлэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөр хамгаалал

65 дугаар зүйл. Хөдөлмөр хамгааллын дүрэм

Улсын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөр хамгааллын нийтлэг дүрмийг БНМАУ-ын Засгийн газар, бусад дүрэм, хөдөлмөрийн стандартыг уг асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

66 дугаар зүйл. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлөөр хангах

1. Захиргаа нь ажилтныг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлөөр хангах үүрэгтэй.

2. Захиргаа хөдөлмөр хамгааллын арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөгөө, хамтын гэрээндээ тусгаж зарцуулна.

67 дугаар зүйл. Хөдөлмөр хамгааллын шаардлага хангаагүй үйлдвэрийн газрыг ашиглаалтад оруулахыг хориглох, үйлдвэрлэлийн ажиллагааг зогсоох

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй үйлдвэрийн газар, байгууллага, түүний нэгжийг ашиглаалтад хүлээн авах, ажиллуулахыг хориглоно.

2. Шинээр барьж байгуулсан буюу өргөтгөл, шинэтгэл хийсэн барилга, байгууламжийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр ашиглаалтад оруулахыг хориглоно.

3. Үйлдвэрийн газар, байгууллага, түүний нэгжийн ажлын нөхцөл, машин, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь ажилтны амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулж болзошгүй байвал тэдгээрийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах хүртэл хугацаагаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр зогсооно.

68 дугаар зүйл. Ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн ахуйн байраар хангах

1. Захиргаа нь хүнд, хортой, халуун нөхцөлд болон газрын дор ажилладаг, түүнчлэн бохирдолтой ажил хийдэг ажилтанд ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл, ариутган цэвэрлэх буюу угаах, хамгаалах бодис үнэгүй олгоно.

2. Ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл, бусад зүйлийг хадгалах, засч сэлбэх, угаах, хатаах, ариутгах, хорт

бодис, хийг арилгах буюу саармагжуулах, үйлдвэрлэлийн ахуйн байраар хангах ажлыг захиргаа хариуцна.

3. Захиргаа нь дортой нөхцөлд ажилладаг ажигтанд сүү буюу хор саармагжуулах хүнсний бусад бүтээгдэхүүн, тусгай хоол, халуун нөхцөлд ажилладаг ажигтанд хийжүүлсэн буюу давстай ус үнэгүй олгоно.

69 дүгээр зүйл. Цаг уурмын тохиромжгүй нөхцөлд ажиллахад олгох завсарлага

1. Захиргаа цаг уурмын нэн тохиромжгүй (хэт халуун буюу хүйтэн зэрэг) нөхцөлд задгай газар, халаалгагүй байранд ажиллаж байгаа ажигтанд хөдөлмөрийн стандартын дагуу түр завсарлага тогтоож олгоно.

2. Түр завсарлагын хугацааг ажилласан цагт оруулан тооцно.

70 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг судлан бүртгэх, мэдээлэх

1. Захиргаа нь үйлдвэрлэлийн осол гарах бүрд БНМАУ-ын Засгийн газрын тогтоосон журмын дагуу ослыг судлан, бүртгэх, акт тогтоох үүрэгтэй.

Ослын акт тогтооход үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

2. Захиргаа ослын акт тогтоохоос татгалзсан, эсхүл осол гарсан шалтгаан, нөхцөлийн тухай дүгнэлтийг ажигтан зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт тавих байгууллагад гаргах эрхтэй. Уул гомдлыг хянан шийдвэрлэсэн байгууллагын шийдвэрийг захиргаа заавал биелүүлэх үүрэгтэй.

3. Захиргаа осолд өртсөн ажигтныг өөрийн уналга, эсхүл зардлаар эмнэлэгт хүргэх, ослын шалтгаан, хор уршгийг арилгах арга хэмжээг цаг тухайд нь авах үүрэгтэй.

4. Үйлдвэрлэлийн ослыг судлах, түүний шалтгаан, нөхцөлийг тогтоохтой холбогдсон зардлыг захиргаа хариуцна.

5. Мэргэжлээс шалтгаалах өвчний шалтгаан, нөхцөлийг эрх бүхий байгууллага судлан тогтооно.

6. Захиргаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тухай мэдээг тогтоосон журмын дагуу мэдээлнэ.

7. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг нуун дарагдуулахыг хориглоно.

71 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг хийлгэх

1. Захиргаа газрын дор болон хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллах ажигтныг анх ажилд ороход нь эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд ажилдаа тэнцэх эсэхийг тогтоохын

хамт, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчлаан сэргийлэх зорилгоор түүнийг эрүүл мэндийн үзлэгт жил тутам оруулж байна.

2. Хүнсний үйлдвэр, худалдаа, нийтийн хоол зэрэг хүн амын үйлчилгээний байгууллага ажилтныг эмнэлгийн үзлэгт тогтоосон журмын дагуу тогтмол оруулж байна.

72 дугаар зүйл. Амь бие, эрүүл мэндэд онц аюультай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоох.

1. Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь бие, эрүүл мэндэд онц аюультай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож энэ тухай захиргаанд мэдэгдэнэ.

2. Захиргаа нь уул нөхцөл байдлыг арилгах шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй.

73 дугаар зүйл. Ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх

Захиргаа эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн ажилтныг түүний зөвшөөрснөөр эрүүл мэндэд нь харшлахгүй өөр нөхцөлийн ажилд шилжүүлэх буюу ажлын нөхцөлийг нь өөрчлөх үүрэгтэй.

74 дугаар зүйл. Тахир дутуу, одой хүмүүсийн хөдөлмөр

1. Тахир дутуу, одой хүмүүсийн биеийн байдал нь хөдөлмөр эрхэлж ажил үйлчилгээ гүйцэтгэхэд саад болохооргүй байвал уг шалтгаанаар тэднийг ажилд авахаас татгалзахыг хориглоно.

2. Захиргаа тахир дутуу, одой хүмүүст тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн дагуу тэдний ажлын цагийг хорогдуулах, ажлын бүтэн бус өдөр, долоо хоног тогтоох, гэрээр ажиллуулах зэргээр хөдөлмөрийн нөхцөлийг нь хөнгөлөх арга хэмжээ авна.

75 дугаар зүйл. Ажилтанд учирсан хохирлыг захиргаа хариуцах

1. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаад захиргааны буруугаас бэртсэн буюу эрүүл мэнд нь хохирсны улмаас ажилтанд учирсан хохирлыг захиргаа нөхөн төлнө.

2. Захиргаа нь хохирлыг ажилтны урьд авч байсан дундаж хөлснөөс эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссоос тодорхойлсон хөдөлмөрийн мэргэжлийн чадвар алдаалтын хэмжээнд ногдох хэсгийн хувьар бодож нөхөн төлөхөөс гадна бэртсэн буюу эрүүл мэнд нь хохирсны улмаас гарсан бусад нэмэгдэл зардал (эвдэрч хэрэгцээ хангаж чадахгүй болсон эд хөрөнгийн үнэ,

эмчлүүлэх, асруулах, сувилуулахтай холбогдсон зардал, хиймэл өрхтэний үнэ зэрэг)-ыг бүрэн хариуцна.

76 дугаар зүйл. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс

1. Тахир дутуу болсныг тогтоох, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хэмжээг тодорхойлох, хөдөлмөрийн чадвар хэсэгчлэн алдсан тахир дутуу хүмүүст хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох асуудлыг эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс шийдвэрлэнэ.

2. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг БНМАУ-ын Засгийн газар батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр

77 дугаар зүйл. Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг ажиллуулахыг хориглох ажил

Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг БНМАУ-ын Засгийн газар батална.

78 дугаар зүйл. Жирэмсэн эмэгтэйчүүд, эхчүүдийг ажлаас халахыг хориглох

Жирэмсэн эмэгтэйчүүд, хоёр (ихэр бол гурван) нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг захиргааны санаачлагаар ажлаас халахыг хориглоно.

79 дүгээр зүйл. Шөнийн буюу илүү цагаар ажиллуулах, албан томилолтоор явуулахыг хязгаарлах

1. Нэг нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг шөнийн буюу илүү цагаар ажиллуулах, албан томилолтоор явуулахыг хориглоно.

Энэ заалт ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.

2. Жирэмсэн эмэгтэйчүүд, 1-ээс 8 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд, 16 хүртэл насны хүүхэдтэй ганц бие эх, эцгийг зөвхөн өөрийнх нь зөвшөөрснөөр шөнийн болон илүү цагаар ажиллуулах буюу албан томилолтоор явуулж болно.

Энэ заалт нярай хүүхэдтэй эцэгт нэгэн адил хамаарна.

80 дугаар зүйл. Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлага

1. Амрах, хооллох нийтийн завсарлагаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан 6 сар хүрээгүй буюу нэг нас хүрээгүй ихэр хүүхэдтэй эхчүүдэд хоёр цагийн завсарлага, 6 сараас нэг

хүртэл насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эх, ганц бие эцэгт нэг цагийн завсарлага олгоно.

2. Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажилласан цагт оруулан тооцно.

81 дүгээр зүйл. Жирэмсний болон амаржсаны амралт

1. Эхчүүдэд хүүхдээ төрүүлэхээс нь өмнө 45 хоног, амаржсаны дараа 56 хоногийн амралт олгоно.

2. Хүндрэлтэй төрсөн эхчүүдэд амаржсаны дараа, ихэр хүүхэд төрүүлэх эхчүүдэд төрөхийн өмнө болон төрсний дараа 70 хоногийн амралт олгоно.

3. Жирэмсний амралтаа бүрэн эдлээгүй эхчүүдэд уг амралтын дутууг амаржсаны дараах амралт дээр нэмж олгоно.

4. Хүүхдээ 196 хоногоос дээш тээгээд дутуу төрүүлсэн буюу эмнэлгийн дүгнэлтээр үр хөндүүлсэн, 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдэд амаржсаны дараах амралт олгоно.

Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн эмэгтэйчүүдэд ажлаас чөлөө олгохдоо өвчний учир чөлөөлөх ердийн журмыг баримтална.

82 дугаар зүйл. Нярай хүүхэд үрчлэн авсан эхэд чөлөө, тэтгэмж олгох

1. Нярай хүүхэд үрчлэн авсан эхэд амаржсан эхийн нэгэн адил хүүхдийг нь 56 хоногтой болтол хугацаагаар чөлөө өгч, тэтгэмж олгоно.

2. Энэ зүйл нярай хүүхэдтэй ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.

83 дугаар зүйл. Эхчүүдэд хүүхдээ асрахад зориулан чөлөө олгох

1. Амаржсаны болон ээлжийн амралтаа эдэлсэн эхэд өөрөө хүсвэл хүүхдээ асрахад зориулж хүүхдийг нь хоёр (ихэр бол гурван) настай болтол зохих тэтгэмжтэй чөлөө олгож, ажил, албан тушаалыг нь хэвээр хадгална.

2. Захиргаа нь хүүхэд асрах чөлөө дууссан, эсхүл дуусаагүй боловч эх өөрөө хүсвэл түүнийг ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн бол түүнд өөр ажил олж өгнө.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсгийн заалт зохих насны хүүхэдтэй ганц бие эцэгт, мөн насны хүүхэд үрчлэн авсан хүмүүст нэгэн адил хамаарна.

84 дүгээр зүйл. Жирэмсэн эмэгтэйчүүд, эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах буюу өөр ажилд шилжүүлэх

1. Хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөхөөр эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн эмэгтэйчүүдийн ажлын цагийг хорогдуулах буюу тэднийг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно. Энэ тохиолдолд урьд авч байсан дундаж хөлсийг хэвээр олгоно.

2. Нэг нас хүрээгүй хүүхэдтэй эхчүүд эрхэлж байгаа ажлаа хийх боломжгүй бол хүүхдийг нь нэг нас хүртэлх хугацаанд тэднийг өөр ажилд шилжүүлж, хэрэв энэ хугацаанд хөдөлмөрийн хөлс нь буурахаар байвал урьд авч байсан дундаж хөлсийг олгоно.

85 дугаар зүйл. Ажилд авахыг зөвшөөрөх нас

1. 16 насанд хүрсэн хүмүүсийг ажилд авна.

2. 15 насанд хүрсэн хүмүүсийг эрүүл мэнд, бие бялдрын хэвийн өсөлт, ёс суртахуунд нь муугаар нөлөөлөхгүй ажилд эцэг, эх буюу тэднийг төлөөлөх хүний зөвшөөрөлтэйгээр авч ажиллуулж болно.

3. 14 насанд хүрсэн хүмүүст мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор эцэг, эх буюу тэднийг төлөөлөх хүний зөвшөөрөлтэйгээр, тэдний хяналтын дор ажиллуулж болно.

86 дугаар зүйл. 18 насанд хүрээгүй ажилтны эрүүл мэндийг хамгаалах

1. 18 насанд хүрээгүй ажилтныг хүнд, хортой, халуун нөхцөлд болон газрын дор ажиллуулахыг хориглоно.

2. 18 насанд хүрээгүй ажилтныг шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно.

3. 18 насанд хүрээгүй ажилтныг эмнэлгийн үзлэгт орсных нь дараа ажилд авах бөгөөд цаашид 18 насанд хүртэл нь хагас жил тутамд эмнэлгийн үзлэгт заавал оруулж байна.

4. 18 насанд хүрээгүй ажилтан эрүүл мэндийн хувьд эрхэлж байгаа ажлаа үргэлжлүүлэн хийж болохгүй тухай эмнэлгийн дүгнэлт гарвал захиргаа уг ажилтанд эрүүл мэндийн байдалд нь тохирсон өөр ажил олгох үүрэгтэй.

5. 18 насанд хүрээгүй ажилтны эрхэлж байгаа ажил эрүүл мэндэд нь хор учруулж байгаа буюу учруулахаар байвал түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт тавих байгууллагын шаардлагаар хөдөлмөрийн гэрээг цуцлана.

АРАВДУГААР БҮЛЭГ

*Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих
хяналт шалгалт*

*95 дугаар зүйл. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд
хяналт шалгалт тавих байгууллага*

1. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн шалгалт шалгалтыг бүх шатны Ардын Хурал, тэдгээрийн гүйцэтгэн захирамжлах байгууллага, улсын хянан байцаах болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага, шүүх, прокурор, БНМАУ-ын хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага тус тусын эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүнэ.

2. Үйлдвэрчний эвлал болон олон нийтийн бусад байгууллага хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтийг эрх хэмжээнийхээ дагуу хянан шалгана.

*96 дугаар зүйл. Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөний
хариуцлага*

Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн буруутай этгээдэд БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу сахлагын, захиргааны, өд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

БНМАУ-ын Бага Хуралын
дэргэ

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хуралын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ХУУЛЬ

1991 оны 1 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ, ХУУЛИЙН ЗААЛТУУД ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль батлагдсантай хөлбөгдүүлэн дараах хууль, хуулийн заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1. БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль (БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар 1973 оны 7 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан).

2. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай БНМАУ-ын хууль (БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн II чуулганаар 1973 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан).

3. Хөдөлмөр, цалин хөлсний улсын хороо, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлд эрх олгох тухай БНМАУ-ын хууль (БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн II чуулганаар 1973 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан).

4. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм батлах тухай БНМАУ-ын хууль (БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн V чуулганаар 1975 оны 12 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан).

5. Зарлигт нэмэлт оруулах тухай БНМАУ-ын хууль (БНМАУ-ын Ардын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар 1977 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан).

6. Хурлын хууль батлах тухай БНМАУ-ын хуулийн 21 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэг (БНМАУ-ын Ардын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн III чуулганаар 1978 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан).

7. Бүх нийтийн цэргийн үүргийн тухай БНМАУ-ын хуулийн 73 дугаар зүйл (БНМАУ-ын Ардын Их Хурлын 10 дахь удаагийн сонгуулийн II чуулганаар 1981 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан).

8. БНМАУ-ын хууль тогтоомжийн зарим актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хуулийн «БНМАУ-ын Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1986 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн зарлиг гэсэн хэсэг (БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар 1986 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан).

9. БНМАУ-ын хууль тогтоомжийн зарим актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хуулийн «БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн 159 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар зарлиг гэсэн хэсэг (БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн III чуулганаар 1987 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан).

10. БНМАУ-ын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хуулийн «Амраатын өдөр болгох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 166 дугаар зарлиг гэсэн хэсэг (БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн VI чуулганаар 1989 оны 6 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан).

11. БНМАУ-ын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хуулийн «Хүүхэд асрах, чөлөө олгох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 202 дугаар зарлиг гэсэн хэсэг (БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн VIII чуулганаар 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан).

12. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулинд нэмэлт оруулах тухай БНМАУ-ын хууль (БНМАУ-ын Улсын Бага Хурлын ээлжит бус чуулганаар 1990 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан).

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 1 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ**

1991 оны 1 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 6

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН ЗАРИМ ТУСГАЙ ШҮҮХИЙГ ТАТАН
БУУЛГАХ, ШИЛЖҮҮЛЭН БАЙРШУУЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

Арвайхээр хот дахь цэргийн тусгай шүүхийг татан буулгаж,
Баруун-Урт хот дахь цэргийн тусгай шүүхийг Чойбалсан хотод
шилжүүлэн байршуулсугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
сарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ**

1991 оны 1 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 7

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН ТУСГАЙ ШҮҮХИЙН ЗАРИМ ШҮҮГЧИЙГ
СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн
5-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Чимэдийн Сануйдагвыг Бүх цэргийн тусгай шүүхийн ор-
логч даргаар;

Цэвэрэнгийн Цэрэнжээг Бүх цэргийн тусгай шүүхийн орлогч дарга бөгөөд Улаанбаатар гарнизоны цэргийн тусгай шүүхийн даргаар;

Өлзийбатын Пүрэв, Самдангийн Баасансүх нарыг Бүх цэргийн тусгай шүүхийн гишүүнээр;

Батцогтын Энхтайваныг Зүүнбаян гарнизоны цэргийн тусгай шүүхийн даргаар;

Бадамцоогийн Идэрчулууныг мөн шүүхийн шүүгчээр;

Цэрэндуламын Дарьбатыг Даланзадгад хот дахь цэргийн тусгай шүүхийн даргаар;

Дашдэндэвийн Хуяг, Дашдаваагийн Чулуунхүү нарыг Улаанбаатар гарнизоны цэргийн тусгай шүүхийн шүүгчээр тус тус сонгосугай.

2. Самдангийн Баасансүхийг Бүх цэргийн тусгай шүүхийн орлогч даргаас, Чимэдийн Сануйдагва, Цэвэрэнгийн Цэрэнжээ нарыг Бүх цэргийн тусгай шүүхийн гишүүнээр;

Өлзийбатын Пүрэвийг Бүх цэргийн тусгай шүүхийн орлогч дарга бөгөөд Улаанбаатар гарнизоны цэргийн тусгай шүүхийн даргаас;

Батцогтын Энхтайваныг Зүүнбаян гарнизоны цэргийн тусгай шүүхийн шүүгчээр;

Дашдэндэвийн Хуягийг Арвайхээр хот дахь цэргийн тусгай шүүхийн даргаас;

Луузандамбын Нямсүрэнг Улаанбаатар гарнизоны цэргийн тусгай шүүхийн шүүгчээр тус тус чөлөөлсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

ЗАРИМ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТУХАЙ

Зохих төслийн боловсруулалтын чанар байдалтай холбогдуулан Улсын Бага Хурлын байнгын хороод, хууль санаачлагчаас гаргасан саналыг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Бага Хурлын II чуулганаар хэлэлцэхээр товлосон Зорчих, цагаачлах тухай, Үйлдвэрчний эвлэлийн тухай, Хэвлэл нийтлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн газруудын тухай, Банкны тухай БНМАУ-ын хуулиудын төслийг БНМАУ-ын Бага Хурлын III чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй.

2. БНМАУ-ын Депутатын тухай хуулийн болон БНМАУ-ын шүүхийн байгууламжийн тухай хуулийн төслийг БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийн төсөлтэй нэгэн зэрэг гүйцээн боловсруулах нь зүйтэй гэж үзсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 1 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар
хот

**БНМАУ-ЫН ГААЛИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Гаалийн хуулийг 1991 оны гуравдугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2. БНМАУ-ын экспорт, импортын барааны гаалийн татварын тарифыг 1, 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батаасугай.

3. БНМАУ-ын Гаалийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай:

а) энэ хуульд БНМАУ-ын хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийг нийцүүлэх;

б) гаалийн байгууллагыг бэхжүүлэх;

в) БНМАУ-ын гаалийн татварын тарифын төслийг олон улсын жишигт нийцүүлэн 1991 онд багтаан боловсруулж БНМАУ-ын Бага Хуралд оруулах.

4. «Гүйлгээний татварын тухай» БНМАУ-ын Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1958 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 206 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
парийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хуралын 1991 оны
1 дүгээр сарын 28-ны өдрийн 9 дүгээр
тогтоолын хавсралт № 1

ЭКСПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН ТАТВАРЫН ТАРИФ

(Хувиар)

№	Барааны нэр	Хувь, хэмжээ
1.	Мал, амьд амьтан	15
2.	Мах, дайвар бүтээгдэхүүн	5
3.	Өлөн гэдэс	10
4.	Өвс, ургамал	10
5.	Бүх төрлийн эрдэс, түүхий эд, хүдэр, баяжмал	20
6.	Боловсруулсан ба боловсруулаагүй арьс шир, ноос, ангийн үс	10
7.	Ноолуур	20
8.	Гуалин	10
9.	Зусмэл	10
10.	Хаягдал хар төмөр, зэс, гууль, өнгөт металл	25

БНМАУ-ын Бага Хуралын 1991 оны
1 дүгээр сарын 28-ны өдрийн 9 дүгээр
тогтоолын хавсралт № 2

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН ТАТВАРЫН ТАРИФ

(Хувиар)

№	Барааны нэр	Хувь, хэмжээ
1.	Хүнсний бараа	5
	— Сүү ба сүүн бүтээгдэхүүн	20
	— Элсэн чихэр, ётон	20
	— Гурил	10
	— Ургамалын тос	10
	— Согтууруулах ундаа	100

— Дүнсэн тамхи	50
— Бусад тамхи	100
— Давс	100
— Цагаан будаа	5
— Кофе	50
— Чихэр, боовны бүтээгдэхүүн	10
2. Өргөн хэрэгцээний бараа	15
— Хоргой, торго	40
— Ноосон даавуу	20
— Сүлжмэл эдлэл	20
— Нэхмэл ба оёмол эдлэл	20
— Бүх төрлийн гутал	30
— Хивс, хивсэнцэр	30
3. Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл	10
4. Гэр ахуйн модон эдлэл	30
5. Химийн бүтээгдэхүүн	5
6. Барилгын бүх төрлийн материал	5
— Цемент	20
7. Үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, түүхий эд	10
— Нүүрс	30
— Цаас	10
8. Бүх төрлийн тээврийн ба хөдлөгч хэрэгсэл	10
— Мотоцикл	40
— Суудамн бүх төрлийн машин	30
9. Бүх төрлийн нефэт бүтээгдэхүүн	10
10. Цахим тоолуур, төхөөрөмж	100
11. Бүх төрлийн аудио, видео төхөөрөмж	100
12. Бүх төрлийн сэлбэг, эд анги	10
13. Нэр дурдаагүй бусад бараа	15

ГААЛИЙН ТАТВАРЫН ТАРИФЫН ТАЙЛАБАР

1. Гаалийн татварын тарифыг гадаад худалдаа, бараа солилцоо, хил орчмын худалдаа, шууд харилцааны шугамаар улсын хил нэвтэрч байгаа бараанд хэрэглэнэ.

2. Гаалийн татварын тарифыг бүх орны бараанд нэгэн жигд хэрэглэнэ.

3. Хүүхдийн бүх төрлийн хүнс тэжээл, хувцасд импортын гаалийн татвар оногдуулахгүй.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр

Дугаар 12

Улаанбаатар

сарын 28-ны өдөр

хот

БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахтай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг 1991 оны 6 дугаар сарын 1-ний дотор авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай:

а) БНМАУ-ын хууль тогтоомж, Засгийн газрын болон улсын хороо, яам, тусгай газар, аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас гаргасан холбогдох актуудыг БНМАУ-ын Хөдөлмөрийн хуульд нийцүүлэх;

б) салбаруудын хооронд харилцан уялдаатай байвал зохих ажлын долоо хоног, өдөр, цагийн дэглэм зэрэг асуудлыг жигдрүүлэх зорилгоор төрийн захиргааны болон хууль хамгаалах байгууллага, улсын үйлдвэр, үйлчилгээний газруудад баримтлах Хөдөлмөрийн нэг маягийн дотоод журам, Хөдөлмөр хамгааллын бүх шатны ажлын зохион байгуулалтын тухай журам болон энэ хуульд тухайлж заасан бусад дүрэм, журам, заанар, аргачлал, жагсаалтыг батлан гаргах;

в) улсын хэмжээнд мөрдөж байгаа бүх төрлийн цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлсний холбогдолтой актуудыг БНМАУ-ын Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн хянаж шинэчлэхийн хамт хөдөлмөрийн хөлсний баталгаат доод хэмжээг тогтоох;

г) хамтын гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих тухай зөвлөмжийг МҮЭ-ийн Холбооны Төв Зөвлөлтэй хамтран гаргах;

д) хөдөлмөрийн эрх зүйн болон техник хяналтын улсын албаны одоогийн зохион байгуулалтыг хянан үзэж боловсруулж болгох.

3. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг мөрдөхөөс өмнө үүссэн хөдөлмөрийн маргааныг уг маргаан үүсэх үед баримталж байсан хуудь тогтоомжийн дагуу шийдвэрлэж байсугай.

4. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар урьд гаргасан тайлбаруудаа хянан үзэж БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн нэн шаардлагатай зүйл, хэсгээр зохих тайлбар гаргахыг БНМАУ-ын Дээд Шүүхэд даалгасугай.

5. Хөдөлмөрийн шинэ хуулиар нийтээр амрах баярын өдрийг 8-аар тогтоосонтой холбогдуулан эдүгээ дагаж мөрдөж байгаа БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн 61 дүгээр зүйлийн «в»-д заасан 5 дугаар сарын 1-ний амралтын өдрийг 1991 оны 2 дугаар сарын 16-нд, 2-ны амралтын өдрийг ажлын өдөрт тус тус шилжүүлэн тооцохыг улс, хоршоолол, олон нийтийн байгууллаага, үйлдвэр, аж ахуйн газарт зөвшөөрсүгэй.

6. Казах үндэстний «Наурыз» баярыг тэмдэглэх өдрийг жилийн амралтын өдрийн тоонд багтааж шийдвэрлэхийг Баян-Өлгий аймгийн Ардын Хуралд зөвшөөрсүгэй.

7. Энэ тогтоолын хавсралтад заасан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, зарлигийн заалт, тогтоолыг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
шарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны
12 дугаар тогтоолын хавсралт

**БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ
БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДОН ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ БНМАУ-ЫН АРДЫН ИХ
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ,
ЗАРЛИГИЙН ЗААЛТ, ТОГТООЛ**

1. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1973 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 243 дугаар зарлиг,

2. Хөдөлмөр, цалин хөлсний улсын хороо, МҮЭ-ийн Төв Зөвлөлд эрх олгох тухай 1973 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 311 дүгээр зарлиг.

3. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм батлах тухай 1974 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 366 дугаар зарлиг.

4. Ажлаас халагдсан тэтгэмжийн тухай 1975 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоол.

5. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөлийг цаашид сайжруулах арга хэмжээний тухай 1976 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 2 дугаар зарлигийн 3 дахь хэсгийн «г» заалт.

6. Зарлигт нэмэлт оруулах тухай 1977 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 110 дугаар зарлиг.

7. Нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөлийн дүрмийн 32 дугаар зүйл (1981 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 441 дүгээр зарлигаар батлагдсан).

8. Баяр ёслолын болон тэмдэглэлт өдрийн тухай 1985 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 137 дугаар зарлигийн 8 дугаар заалт.

9. Нийгмийн тустай хөдөлмөрөөс зайлсхийх, хөдөлмөрийн сахлага зөрчих явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай 1986 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 5 дугаар зарлиг.

10. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1986 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 6 дугаар зарлиг.

11. Заавар батлах тухай 1987 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол.

12. БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн 159 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах тухай 1987 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар зарлиг.

13. Амралтын өдөр болгох тухай 1988 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 166 дугаар зарлиг.

14. Хүүхэд асрах чөлөө олгох тухай 1989 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 202 дугаар зарлиг.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

БНМАУ-ЫН ШҮҮГЧИЙН ТАНГАРАГ
БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын шүүгчийн тангарагийг хавсралтын ёсоор батал-
сугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
сарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны
13 дугаар тогтоолын хавсралт

БНМАУ-ЫН ШҮҮГЧИЙН ТАНГАРАГ

Шүүгч би гагцхүү БНМАУ-ын хуулийг эрхэмлэн дээдэлж,
хэний ч нөлөөнд үл автан ажиллаж, шүүгчийн ариун нэр төрийг
өндөрт өргөж явахад батлан тангараглая.

Хэрэв миний бие өргөсөн тангарагаасаа няцвал төрийн хуу-
лийн хатуу цээрлэл хүлээнэ.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

МӨНГӨНИЙ ХУВААРЬ (МАСШТАБ)
ӨӨРЧЛӨГДСӨНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ХУУЛЬ,
ЗАРЛИГ, ТОГТООЛЫН ЗАРИМ ЗААЛТЫГ
ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1991 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс өмнө батлагдсан бөгөөд хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа БНМАУ-ын хууль, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, тогтоол, БНМАУ-ын Бага Хурлын тогтоолд заасан төгрөг, мөнгөний хэмжээг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 1991 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хоёр дахин нэмэгдүүлэн тооцож хэрэглэхээр тогтоосугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
варийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 1 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Бага Хурлын Байнгын хорооны дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны
15 дугаар тогтоолын хавсралт

**БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДҮРЭМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэл үндэслэл

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Бага Хурлын Байнгын хороо нь (цаашид «Байнгын хороо» гэх) БНМАУ-ын Бага Хурлын (цаашид «Улсын Бага Хурал» гэх) тасралтгүй үйл ажиллагааг хангах, түүний ажлын байнгын байгууллага мөн.

2 дугаар зүйл. Байнгын хороодын төрөл, бүрэлдэхүүнд нь байх гишүүдийн тоог Улсын Бага Хурал тогтоож, өөрийн ги-

шүүдийн дотроос тэдгээрийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй батална.

Байнгын хорооноос гадна түр хороо, дэд хороог Улсын Бага Хурлаас тухайн үед нь шийдвэр гарган байгуулж болно.

3 дугаар зүйл. Байнгын хорооны гишүүдийг ил санал хураалтын журмаар Улсын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаагаар Улсын Бага Хурлаас сонгоно. Улсын Бага Хурлын гишүүн аль нэг Байнгын хороонд харьяалагдах бөгөөд түүний Байнгын хорооны харьяаллыг өөрчлөх асуудлыг Улсын Бага Хурал шийдвэрлэнэ.

Байнгын хорооны даргыг гишүүд саналаа нууцаар гаргаж, нэг жилийн хугацаагаар Улсын Бага Хурлаас сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно. Байнгын хорооны даргын сонгуульд нэр дэвшүүлэх эрхийг холбогдох Байнгын хороо нэн тэргүүнд эдэлнэ.

4 дүгээр зүйл. Байнгын хороо үйл ажиллагаагаа БНМАУ-ын Үндсэн хууль, БНМАУ-ын Бага Хурлын тухай хууль, БНМАУ-ын Бага Хурлын үйл ажиллагааны дэг, энэ дүрэм болон хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн явуулна.

Түр хороо, дэд хорооны эрх, үүрэг, эрхлэх ажлын талаар тэдгээрийг байгуулах тухай Улсын Бага Хурлын шийдвэрт заана.

5 дугаар зүйл. Байнгын хороо жилд нэг удаа ажлаа Улсын Бага Хуралд хариуцан тайлагнана.

6 дугаар зүйл. Байнгын хороо нь тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЕРДУГААР БҮЛЭГ

Байнгын хорооны үүрэг, эрх

7 дугаар зүйл. Байнгын хороо нь Улсын Бага Хурлын хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэхэд ажлаа бүрэн чиглүүлж дор дурдсан үндсэн үүрэг гүйцэтгэнэ:

1) Улсын Бага Хурлын чуулган, түүний хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;

2) Улсын Бага Хурлаар хянан хэлэлцэх хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг боловсруулах;

3) Улсын Бага Хурлаар хянан хэлэлцэх хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг судалж өөрийн дүгнэлт, саналыг гаргах;

4) БНМАУ-ын хууль, Ардын Их Хурлын тогтоол, Улсын Бага Хурлын тогтоол болон бусад шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч, шалгаж дүгнэх;

5) иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хянан үзэж шийдвэрлэх талаар арга хэмжээ авах.

8 дугаар зүйл. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлаар дор дурдсан эрх эдэлнэ:

1) Улсын Бага Хурлаас батлагддаг албан тушаалтнуудыг сонгох, томилох, чөлөөлөх тухай саналаа Улсын Бага Хуралд оруулах;

2) Засгийн газрын гишүүн, Улсын Дээд шүүхийн дарга, Улсын Ерөнхий прокурор, Засгийн газрын дэргэдэх тусгай газрын дарга, орон нутгийн хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны даргын налтга, сонголыг хэлэлцэх, тэдэнд асуулга тавих;

3) байгууллага, иргэдээс Улсын Бага Хуралд ирүүлсэн хуулийн төсөл болон бусад асуудлыг хянан үзэж Улсын Бага Хуралд хэлэлцүүлэхээр оруулах;

4) БНМАУ-ын хууль, Ардын Их Хурлын тогтоол, Улсын Бага Хурлын тогтоол болон бусад шийдвэрийн биелэлтийг даingaараа буюу мэргэжлийн байгууллагыг татан оролцуулж хянан шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд гэм буруутай этгээдийг хариуцлага хүлээлгэхээр зохих байгууллагад шилжүүлэх;

5) өөрийн эрхлэх асуудалд шаардагдах судалгаа, тайлан мэдээ, тодорхойлолт зэрэг баримт бичгийг холбогдох байгууллагаас гаргуулан авах,

6) асуудлыг шалган судлах, сайтар бэлтгэх зорилгоор холбогдох байгууллагын ажилтан болон өрдөмтөн, мэргэжилтнэвс бүрдсэн ажлын хэсгийг дэргэдээ байгуулах.

9 дүгээр зүйл. Төрийн байгуулалтын байнгын хороо дор дурдсан асуудал эрхэлнэ:

1) хууль тогтоох, гүйцэтгэх, шүүн таслах засаглалын тогтолцоог төлөвшүүлэх, боловсронгуй болгох талаар бодлого боловсруулах;

2) төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын тогтолцоо, орон нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;

3) бүх шатны Ардын Хурлын депутатын сонгууль, ард түмний санал асуулга, санал хураалт явуулах тухай асуудлыг урьдчилан боловсруулах;

4) БНМАУ-ын төрийн байгууламж, засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарилалт, хилийн цэсийн асуудлаар санал, дүгнэлт бэлтгэх;

5) Засгийн газрын Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг урьдчилан хянан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах;

6) БНМАУ-ын үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны үзэл баримтлалыг тодорхойлж, холбогдох хуулийн төсөл боловсруулж Улсын Бага Хуралд оруулах;

7) Засгийн газраас БНМАУ-ын үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны салбарт явуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, эдгээр салбарыг хариуцсан Засгийн газрын гишүүн, тусгай газрын даргыг томилж, чөлөөлөх асуудлаар санал, дүгнэлт гаргах;

8) үндэстний асуудлаар төрөөс явуулах бодлогыг боловсруулах;

9) БНМАУ-аас бусад улстай дипломат харилцаа тогтоох, таслах асуудлыг урьдчилан хянан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах;

10) БНМАУ-ын олон улсын гэрээг Улсын Бага Хурлаас соёрхон батлах, цуцлах асуудлыг холбогдох Байнгын Хороотой хамтран урьдчилан хянан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

11) БНМАУ-аас гадаад улсад болон олон улсын байгууллагад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчдийг томилж, эгүүлэн татах талаар урьдчилан танилцаж саналаа БНМАУ-ын Ерөнхийлөгчид уламжлах;

12) БНМАУ-ын хүндэт цол, одон, медаль, цэргийн дээд цол болон бусад алдар цол бий болгох, өөрчлөх асуудлыг урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах.

10 дугаар зүйл. Хууль зүйн байнгын хороо дор дурдсан асуудал эрхэлнэ:

1) хууль дээдлэх ёсны хэрэгжлэлтийг хангах, шүүн таслах засаглалыг төлөвшүүлэх, эрх зүйн шинэчлэлийн асуудлаар төрийн бодлого боловсруулах;

2) хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдох хуулиудыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр боловсруулсан хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах;

3) бусад Байнгын хорооноос хуулийн төсөл боловсруулахад хүсэлтээр нь оролцох, санал, дүгнэлт гаргах;

б) Улсын Дээд шүүхийн дарга, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх, Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилж,

4) гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг урьдчилан сэргийлэх асуудлаар хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулах;

5) Улсын Бага Хурлаас өршөөл үзүүлэх асуудлыг урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах;

чөлөөлөх, Хууль зүйн сайдыг томлох, чөлөөлөх тухай санаал, дүгнэлт гаргах;

7) Улсын Бага Хурлаас баталсан хуулийг батламжлуулахаар БНМАУ-ын Ерөнхийлөгчид өргөн барихын өмнө хянан үзэх.

11 дугаар зүйл. Эдийн засгийн байнгын хороо дор дурдсан асуудал эрхэлнэ:

1) эдийн засгийн салбарт төрөөс явуулах гадаад, дотоод бодлогыг тодорхойлох;

2) эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон хуулийн төсөл боловсруулах, энэ асуудлаар Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас Улсын Бага Хуралд оруулсан хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг урьдчилан хэлэлцэж, санаал, дүгнэлт гаргах;

3) Улсын Бага Хурлаар батлуулахаар Засгийн газраас оруулсан БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, БНМАУ-ын төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тухай тайланг урьдчилан хэлэлцэж, санаал, дүгнэлт гаргах;

4) Засгийн газрын эдийн засгийн асуудал хариуцсан гишүүдийг томлох, чөлөөлөх асуудлаар санаал, дүгнэлт гаргах.

12 дугаар зүйл. Нийгмийн бодлогын байнгын хороо дор дурдсан асуудал эрхэлнэ:

1) төрөөс явуулах нийгмийн бодлого, нийгмийн асуудалд холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах;

2) Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас Улсын Бага Хуралд оруулсан нийгмийн асуудалтай холбоотой хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг урьдчилан хэлэлцэж, санаал, дүгнэлт гаргах;

3) Улсын Бага Хуралд Засгийн газраас оруулсан БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд болон БНМАУ-ын төсвийн хуваарилалтад нийгмийн асуудлыг усгасан байдлыг урьдчилан хэлэлцэж, санаал, дүгнэлт гаргах;

4) нийгэм, соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүдийг томлох, чөлөөлөх асуудлаар санаал, дүгнэлт гаргах;

5) нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж, татвар, цалин хөлс, мөдөлмөр эрхлэлтийн талаар Эдийн засгийн байнгын хороотой замтран төрөөс явуулах бодлогыг боловсруулах, энэ талаар Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас Улсын Бага Хуралд оруулсан хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлын талаар санаал, дүгнэлт гаргах;

6) хүн ам зүй, шинжлэх ухаан, боловсрол, эрүүлийг хамгаалах, соёл, урлаг, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, байгаль орчныг хамгаалах асуудал, шашны талаар төрөөс явуулах бодлого, холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах, энэ талаар Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас Улсын Бага Хуралд оруулсан хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлын талаар санаал, дүгнэлт гаргах.

13 дугаар зүйл. Эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын асуудлын байнгын хороо дор дурдсан асуудал эрхэлнэ:

1) эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын талаар төрөөс явуулах бодлого, холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах;

2) эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын эрх ашигтай холбогдсон асуудлаар Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас Улсын Бага Хуралд оруулсан хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах;

3) Улсын Бага Хуралд Засгийн газраас оруулсан БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд болон БНМАУ-ын төсвийн хуваарилалтад эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын нийгмийн асуудал, эрүүл мэнд, боловсрол, хүмүүжилд зориулах хөрөнгийн хэмжээг тусгасан байдлыг урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлт гаргах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

14 дүгээр зүйл. Байнгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Гишүүдийн олонхи нь ирснээр Байнгын хорооны хуралдаан хүчин төгөлдөр болно. Байнгын хорооны дарга, гишүүд хуралдаанд таслах эрхтэй оролдоно.

Хуралдааныг сард хоёроос доошгүй удаа хийх бөгөөд шаардлагатай гэсэн тохиолдолд Байнгын хорооны гишүүдийн олонхи нь хүсвэл, эсхүл Байнгын хорооны даргын саналаар хуралдааныг зарлан хуралдуулж болно.

Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал нийлээгүй гишүүн саналаа Улсын Бага Хурлын чуулганд танилцуулах эрхтэй.

Байнгын хорооны хуралдааны явц болон гаргасан шийдвэрийг протоколд тэмдэглэнэ. Байнгын хороо шаардлагатай асуудлаар тогтоол гаргана.

Байнгын хорооны хуралдааны талаарх бусад асуудлыг БНМАУ-ын Бага Хурлын үйл ажиллагааны дэгд заасны дагуу зохицуулна.

15 дугаар зүйл. Байнгын хороо хэтийн болон жилийн төлөвлөгөөтэй ажиллана. Хэтийн төлөвлөгөөг Улсын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаагаар хийнэ. Хэтийн болон жилийн төлөвлөгөөг Байнгын хорооны хуралдаанаар батална.

16 дугаар зүйл. Байнгын хорооны дарга нь:

- 1) Байнгын хорооны ажлыг зохион байгуулж удирдана;
- 2) Байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг зохион байгуулж, хуралдааныг даргална;
- 3) Байнгын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харьдана;
- 4) Байнгын хорооны ажлыг Улсын Бага Хурлын өмнө харууцан тайлаглана.

Байнгын хорооны даргын эзгүйд түүнийг үүргийг Байнгын хорооны шийдвэрээр аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл. Байнгын хорооны гишүүн нь Байнгын хорооны эрхлэх асуудлын өөрт нь харууцуулсан ажил үүргийг биелүүж, үүний тулд Байнгын хороо, Улсын Бага Хурлын удирдлагаас зохих дэмжлэг, туслаацаа авах эрхтэй.

18 дугаар зүйл. Байнгын хорооны эрхлэх асуудлын чиглэлээр мэргэжлийн хүмүүсийг зөвлөгчөөр ажиллуулж болно. Холбогдох Байнгын хорооны зөвшөөрлийг үндэслэн Улсын Бага Хурлын Тамгын газар тухайн хүнийг зөвлөгчөөр томилон ажиллуулна.

Зөвлөгч нь Байнгын хорооны гишүүдэд тодорхой асуудлаар зөвлөгөө өгөх, хууль, тогтоолын төсөл болон бусад асуудал боловсруулахад оролцох, Байнгын хорооны хуралдааны шийдвэрээр үзлэг шалгалт хийхээс гадна Байнгын хорооны хуралдаанд зөвлөх эрхтэй оролцоно.

19 дүгээр зүйл. Байнгын хороо туслахтай байна. Байнгын хорооны туслах нь Байнгын хорооны бичиг хэргийн ажлыг хөтлөх, гишүүдийг төрөл бүрийн мэдээллээр хангах зэрэг хорооны дотоод зохион байгуулаалтын ажлыг эрхэлнэ.

20 дугаар зүйл. Байнгын хорооноос үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд Улсын Бага Хурлын Тамгын газар туслах үйлчилнэ.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЛЭГЧИЙН ЗАРИГ

1991 оны 1 дүгээр
сарын 02-ны өдөр

Дүгээр 1

Улаанбаатар
хот

ДИПЛОМАТ АЖИЛТНЫ ТАНГАРАГ БАТЛАХ
ТУХАЙ

БНМАУ-ын Дипломат ажилтны тангаргийг дор дурдсанаар
батаалсугай.

БНМАУ-ЫН ДИПЛОМАТ АЖИЛТНЫ ТАНГАРАГ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэн би,

Монгол улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт
байдал, үндэсний эрх ашгийг ямагт дээдэлж,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад бодлогыг хэрэг-
жүүлэх үйлст үнэнч шударгаар хичээн зүтгэж, дипломат ажилт-
ны нэр төрийг эрхэмлэн, улсын нууцыг чандлан хадгаж ява-
хаа төрийнхөө сүлдэнд сүсэглэн тангараглая.

Миний бие өргөсөн тангаргаасаа илцвал төрийн хуулийн
эмнэ бүхий а хариуцлагыг хүлээх болно.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЯЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 2 дугаар

Дугаар 6

Улаанбаатар

сарын 4-ний өдөр

хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Төрийн соёрхолын тухай дүрмийг нэгдүгээр хавсралтаар, БНМАУ-ын Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн дүрмийг хоёрдугаар хавсралтын ёсоор баталсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Ерөнхийлөгчийн 1991 оны 6 дугаар
зарлигаар батлан.

БНМАУ-ЫН ТӨРИЙН СОЁРХОЛЫН ТУХАЙ ДҮРЭМ

1. БНМАУ-ын Төрийн соёрхолыг шинжлэх ухаан, техникийн томоохон нээлт, ололт, технологийн туйлын оновчтой шийдэл, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн онцгой амжилт гаргасан, үндэсний соёл, урлаг, утга зохиол, уран барилгын шилдэг бүтээл туурвиж амжилт бүтээлээрээ гадаад дотоодод алдаршсан олон нийтийн хүндэтгэлийг хүлээсэн хүмүүст хүртэнэ.

2. Төрийн соёрхол хүртээх хүний нэрийг тус улсын яам, тусгай газар, шинжлэх ухаан, зураг төсөл, зохион бүтээх байгууллага, их, дээд сургууль, олон нийтийн болон соёл, урлаг, уран бүтээлийн авлаа, холбоод, үйлдвэр, нэгтгэлүүдийн хөдөлмөрийн хамт олон олонхийн саналаар дэвшүүлнэ. Төрийн соёрхолд нэр дэвшүүлэхдээ гаргасан бүтээлийн ач холбогдол, практик үр өгөөж, хамрах хүрээ, нөлөө, зохиогчийн оруулсан бодит хувь нэмрийг үндэслэлтэй үнэн зөв тодорхойлно.

3. Төрийн соёрхол хүртээхээр нэрийг нь дэвшүүлсэн шинжлэх ухаан, техник, технологи, архитектур, үндэсний соёл, урлаг

гийн бүтээл, уран зохиол нь олны хүртээл болсон, түүнийг олон түмэн сайн мэдэрч өндөр үнэлсэн, үйлдвэрлэлийн дээд амжилтад хүрсэн бүтээл, бүтээгдэхүүн нь хэмжээ, чанар хүртээц нөөцлөөрөө урьд байгаагүй тогтвортой дээд үзүүлэлтийг хангасан байна.

4. Төрийн соёрхол хүртээхээр нэрийг нь дэвшүүлж буй хүмүүсийн талаар нэр дэвшүүлэгч байгууллага, хамт олноос дараах материалыг бүрдүүлж БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх зөвлөлд жил бүрийн 1 дүгээр сарын 2-ноос 4 дүгээр сарын 1 хүртэл хугацаанд ирүүлнэ.

а) бүтээлийн товч тодорхойлолт, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр, техникийн баримт бичиг, зураг, бүдүүвч, эдийн засгийн үзүүлэлт, байгууллага, хамт олны хуралдааны шийдвэр;

б) нээлт, шинэ, шинэчилсэн бүтээл, бүтээгдэхүүн, техник, технологийн шийдэл, зураг төсөл зохиогчийн эрхийн хамгаалалт хийсэн тухай баримт бичгийн хувилбар;

в) төрийн соёрхол хүртээхээр нэрийг нь дэвшүүлж буй бүтээлийг дотоод, гадаадад олон нийт хэрхэн үнэлж дүгнэж байгаад холбогдох материал;

— уг бүтээлийг хэрэглэгч байгууллага, хамт олноос гаргасан тодорхойлолт, толгойлох байгууллаагынх нь үнэлэлт, шүүмж;

— бүтээлийн зохиогчдын ажил байдлын тодорхойлолт, товч намтар.

5. БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх зөвлөл төрийн соёрхол хүртээхээр нэрийг нь дэвшүүлсэн бүтээлүүдийг зөвлөлийнхөө гурван салбарын чиглэлээр хэлэлцүүлж дүгнэлт гаргасны үндсэн дээр сонгосон бүтээлүүдийн тухай материалыг «Ардын эрх» сонинд нийтлүүлж, олон нийтээр ил тод хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.

6. БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх зөвлөл сонгосон бүтээлүүдийг олон нийтээр шүүн хэлэлцүүлсэн дүнг үндэслэн дахин сонголт хийж шалгарсан бүтээлд төрийн соёрхол хүртээх тухай БНМАУ-ын Засгийн газартай санал тохиролцсоны үндсэн дээр тогтоол гаргаж батламжлуулахаар Ерөнхийлөгчид өргөн барина.

7. БНМАУ-ын нэг жилд олгох төрийн соёрхолын тоо 7 хүртэл байж болно. Төрийн соёрхол нэг бүрийн хэмжээ 50000 төгрөг байна.

БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх тухай төрийн соёрхол хүртээх зөвлөлийн тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигийг «Ардын эрх» сонинд нийтэлнэ.

8. БНМАУ-ын төрийн соёрхолыг монгол ардын хувьсгалын ойн баяр тохиолдуулан жил бүрийн 7 дугаар сард БНМАУ-ын Ерөнхийлөгч төрийн соёрхолын диплом, энгэрийн тэмдгийн хамт гардуулна. Төрийн соёрхол хамтран хүртэгчдэд соёрхолыг хуваарилахдаа уг бүтээлд тэдгээрийн биечлэн оруулсан бодит хувь нэмрийг харгалзан дөр дурдсан хувь хэмжээг баримтална:

— хоёр зохиогчтой бол соёрхолын 60 хувийг үндсэн зохиогчид, 40 хувийг хамтран зохиогчид;

— гурван зохиогчтой бол соёрхолын 50 хувийг үндсэн зохиогчид, үлдсэн хэсгийг тэнцүү хувааж хамтран зохиогчдод;

— дөрөв буюу түүнээс дээш тооны зохиогчтой бол соёрхолын 40 хувийг үндсэн зохиогчид, үлдсэн хувийг тэнцүү хувааж бусад хамтран зохиогчдод;

— үндсэн зохиогч тогтоогдоогүй бол соёрхолыг зохиогчдод тэнцүү хувааж олгоно.

9. Тухайн бүтээлээрээ БНМАУ-ын одон медаль, алдар цол, Засгийн газрын болон түүнтэй тэнцэх бусад шагнаал хүртсэн бол уг бүтээлд төрийн соёрхол давхардуулан олгохгүй. Харин төрийн шагналаас өөр шагнаал хүртсэн бүтээл энэхүү дүрмийн дагуу шалгаруулан төрийн соёрхол олгоход саад болохгүй.

10. Төрийн соёрхол хүртэгч нас барсан, эсхүл төрийн соёрхолыг нэхэн олгосон бол, төрийн соёрхолын диплом, энгэрийн тэмдгийг түүний гэр бүл, үр хүүхдэд нь дурсгал болгон шилжүүлнэ.

Төрийн соёрхолын мөнгийг хуульд заасан журмаар өв залгамжлагчдад нь олгоно.

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны
6 дугаар зарлигаар баталв.

БНМАУ-ЫН ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

I. Нийтлэг үндэслэл

1. БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх зөвлөл нь БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх асуудлыг эрхэлж БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэд ажиллах орон тооны бус байгууллага мөн.

2. Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн бүрэлдэхүүнийг БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар батална. Зөвлөлийн бү-

рэлдэхүүн, түүнд орсон өөрчлөлтийг «Ардын эрх» сонинд нийтэлнэ.

3. Төрийн соёрхол хүртээх зөвлөл нь дотроо шинжлэх ухаан, техник, технологийн; үндэсний соёл, урлаг, утга зохиол, уран барилгын; хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбаруудтай байна.

4. Төрийн соёрхол хүртээх зөвлөл нь тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

II. Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн эрх үүрэг

5. төрийн соёрхол хүртээх зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а) БНМАУ-ын төрийн соёрхолд дэвшүүлсэн бүтээлтэй газар дээр нь танилцаж магадлан шинжилгээ хийх мэргэжилтэн, мэргэжилтний хэсэг томилон ажиллуулах;

б) шаардлагатай бол нэмэлт материал авах;

в) БНМАУ-ын төрийн соёрхолд дэвшүүлсэн бүтээлийг хянан хэлэлцэхийг үйлдвэр, аж ахуйн газар, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, бусад байгууллага, хөдөлмөрийн хамт олонд хүсэх;

г) БНМАУ-ын төрийн соёрхолд дэвшүүлсэн бүтээлд шүүмж гаргуулах, магадлан шинжилгээ хийлгэх ажилд эрдэмтэн, мэргэжилтэнг урьж оролцуулах.

6. Төрийн соёрхол хүртээх зөвлөл дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) БНМАУ-ын төрийн соёрхолд дэвшүүлсэн бүтээлүүдийг Зөвлөлийн салбаруудаар хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр олон нийтээр хэлэлцүүлэх бүтээлийг сонгож авах;

б) сонгож авсан бүтээлүүдийн тухай материалыг «Ардын эрх» сонинд нийтлүүлж, олон нийтээр ил тод хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, уг хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг үндэслэн БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх бүтээлийг шалгаруулах;

в) БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх тухай саналаа БНМАУ-ын Засгийн газарт урьдчилан танилцуулж санал тохиролцоо.

III. Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэр

7. Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн хуралдааныг гинжүүдийнх нь гуравны хоёроос доошгүйн ирдтэйгээр хийнэ.

8. Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн дарга, эзгүйд нь зөвлөлийн орлогч дарга удирдана. Хуралдааны протоколыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлнө.

9. Олон нийтээр хэлэлцүүлсэн бүтээлийг гарсан саналыг үндэслэн зөвлөлийн салбаруудын хуралдаанаар тус тусын чиг-

дэлвэр хэлвэцгэж шалгаруулна. Зөвлөлийн гурван салбараас шалгаруулсан бүтээлийг Зөвлөлийн хуралдаанаар хянан хэлвэцгэж, нууц санал хураалтаар хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн санал авсан бүтээлийг шалгаруулж БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх тухай тогтоол гаргана.

10. БНМАУ-ын төрийн соёрхол хүртээх зөвлөлийн тогтоолыг БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилснаар хүчин төгөлдөр болно.

11. Төрийн соёрхол хүртээсэн тогтоолын үнэн зөвийг төрийн соёрхол хүртээх зөвлөл хариуцна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЛЭГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 2 дугаар

Дугаар 7

Улаанбаатар

сарын 4-ний өдөр

хот

БНМАУ-ЫН ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ БАТАЛАХ
ТУХАЙ

БНМАУ-ын Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай.

Зөвлөлийн дарга К. Зардыхан — Улсын Бага Хурлын орлогч дарга, түүхийн ухааны доктор

Зөвлөлийн орлогч дарга, шинжлэх ухаан, техник технологийн салбарын дарга

Х. Намсрай — Физик техникийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, физик математикийн ухааны доктор

Зөвлөлийн орлогч дарга, соёл, урлаг, утга зохиол, уран барилгын салбарын дарга

Ж. Бадраа — Соёлын гавьяат зүтгэлтэн, урлаг судлаач

Зөвлөлийн орлогч дарга, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарын дарга

Ш. Батбаяр — Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төв зөвлөлийн дарга, эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн

Зөвлөлийн нарийн бичгийн дарга

М. Төмөржав — ШУА-ийн дэд ерөнхийлөгч, сурвалжлагч гишүүн биологийн ухааны доктор

Гишүүд:	Д. Дорж	— МУИС-ийн ректор профессор
	Ж. Батсуурь	— Үндэсний хөгжлийн сайд, биологийн ухааны доктор
	Ч. Авдай	— Техникийн их сургуулийн ректор, техникийн ухааны доктор, профессор
	П. Долгор	— АУИС-ийн тэнхмийн эрхлэгч, анэгэлх ухааны доктор, төрийн шагналт
	А. Магаш	— ХААДС-ийн багш, мал эмцэлгийн ухааны доктор
	М. Энхсайхан	— Улсын Бага Хурлын байнгын хорооны дарга, эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн
	Е. Норовсүрэн	— БНМАУ-ын хөдөлмөрийн баатар
	Ц. Батдэлгэр	— Төв аймгийн Эрдэнэсант сумын Саруул амьдрал нэгдлийн хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар
	С. Гүндэнбал	— Булган аймгийн Ардын Хурлын Тэргүүлэгчдийн дарга
	Д. Дондов	— Эрчим хүчний дэд сайд
	Г. Болд	— Барилга, хот байгуулалтын комиссын дэд дарга
	Ц. Даваадорж	— Дархан дахь Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, хөдөө аж ахуйн ухааны дэд эрдэмтэн
	Н. Жанцанноров	— БНМАУ-ын төрийн шагналт, хөгжмийн зохиолч
	Г. Лувсандорж	— БНМАУ-ын төрийн шагналт, архитекторч

- Д. Норовбанзад — БНМАУ-ын Ардын жүжигчин, төрийн шагналт
- Х. Намбуу — МУИС-монгол судлаачин төвийн захирал, философийн ухааны дэд эрдэмтэн
- Б. Ахагнасүрэн — БНМАУ-ын төрийн шагналт, яруу найрагч
- Д. Бүтэмж — Монголын урчуудын эвлэлийн хорооны дарга

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИВЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 2 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

**БНМАУ-ЫН СПОРТЫН ГАВЬЯАТ
ДАСГААЖУУЛАГЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Боксын дасгаажуулагчаар олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж, спортын энэ төрлөөр улсын болон олон улсын зэрэг цолтой тамирчдыг бэлтгэхэд өндөр амжилт гаргаж байгааг үнэлж, боксын улсын шигшээ багийн ахлах дасгаажуулагч Вандуйн БАТБАЯРТ БНМАУ-ЫН СПОРТЫН ГАВЬЯАТ ДАСГААЖУУЛАГЧ цол олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИВЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 2 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

**БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Олимп, дэлхий, тивийн болон олон улсын тэмцээнд удаа дараа өндөр амжилт гаргаж байгааг үнэлж, бөхийн самбо, жүдо барилдааны улсын шигшээ багийн тамирчин Жамбалын ГАНБОЛД, Дашгомбын БАТТУЛГА, бөхийн чөлөөт барилдааны улсын шигшээ багийн тамирчин Пунцагийн СҮХБАТ, бөхийн

жүдо барилдааны эмэгтэйчүүдийн улсын шигшээ багийн тамирчин Ахамласүрэнгийн БАДАМСҮРЭН нарт БНМАУ-ын ГАВЬЯТ ТАМИРЧИН цол олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 2 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

ЗАРИМ ТАМИРЧДЫГ ШАГНАХ ТУХАЙ

Олон улсын болон өөрийн оронд зохиогдсон тэмцээнүүдэд удаа дараа спортын өндөр амжилт гаргаж байгааг үнэлж дор дурдсан хүмүүсийг БНМАУ-ын одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН
ОДОНГООР:

— Бандийн ГЭЛЭГ — Хүч нийгэмлэгийн дасгал-жуулагч

АЛТАН ГАДАС ОДОНГООР:

— Адуучийн БАСХҮҮ — Бөхийн чөлөөт барилдааны улсын шигшээ багийн ахлах дасгалжуулагч
— Батсүхийн ХАЯНХЯРВАА — Дугуйн улсын шигшээ багийн тамирчин
— Дашиямын ТӨМӨР-ОЧИР — мөн багийн тамирчин

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

— Лодойн ЭНХБАЯР — Бөхийн чөлөөт барилдааны улсын шигшээ багийн тамирчин

— Лодойн ЭРХБАЯР — мөн багийн тамирчин
— Халтмаагийн БАТ-ТУУЛ — мөн багийн тамирчин

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЯЛАӨГЧИЙН ЗАРАЛГ

1991 оны 2 дугаар

Дугаар 33

Улаанбаатар

сарын 13-ны өдөр

хот

МИГЖЭД ЖАНРАЙСИГ ШҮТЭЭНИЙГ БҮТЭЭН ЗАЛАХ ТУХАЙ

1. Монголын түүх, соёлын хосгүй нандин өвийн нэг Мигжэд Жанрайсиг шүтээнийг бүтээн залах тухай хөдөлмөрчид, ард иргэд, сүсэгтэн олноос гаргасан санаачилгыг үндэслэн энэхүү шүтээнийг бүтээн урлах талаар Монголын соёлын сан, Монголын урчуудын эвлэлийн хорооноос дэвшүүлсэн санааыг зүйтэй гэж үзсүгэй.

2. Мигжэд Жанрайсиг шүтээнийг бүтээн залахад зориулан өргөн олон түмнээс өргөсөн хандивын зэрэгцээ, хэрэгцээт эрдэвсний зүйл, үнэт металаа, шаардагдах хөрөнгийг улсын сан, төсвөөс гарган, уг шүтээнийг 1994 онд БНМАУ-ыг тунхагласан 70 жилийн ойгоор цогцлуулан аравнайлах арга хэмжээ авчмыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Эмэлтэсэн Б. Одоожиа
Техник редактор Б. Оюундэлгэр
Хянагч С. Итгэл

Зах № 214

Үйлдвэрт шилжүүлсэн 1991 оны 2-р сарын 26-нд,
Өрөөлөд 1991 оны 3-р сарын 6-нд, Хэвлэлтэд
1991 оны 3-р сарын 13-нд, Цэвэр хэмжээ
60х90/16, Хэвлэлийн хуудас 3,25, Хэвлэсэн тоо
13000 ширхэг, Үнд 4 төгрөг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр